82

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2014.12.11 № ХЭГ/10949

танай _____-ны № 49 -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.БАЯРМАА ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Төсвийн тухай хууль тогтоомжийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Сангийн сайдаас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцахыг хүсье.

Хавсралт 102 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ

0002 5020914

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД
Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот.
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024-10-15 № 01/8474

танай 2024.9.30-ны № ХЭГ/1848-Т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Төсвийн тухай хууль тогтоомжийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагаас ирүүлсэн асуулгатай танилцлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн ирүүлсэн асуулгын дагуу холбогдох мэдээллийг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр гарган хүргүүлж байна.

Хавсралт 101 ..... хуудас

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761002718

## ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ТАЙЛБАР, ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

| Асуулга | Зөрчлийн агуулга | Зөрчил үүссэн тайлбар | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | **Асуулга 1- Зөрчил 1 заасан авлагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, барагдуулж буй үйл явц,төлөвлөгөө** | | |
| 1 | **Зөрчил-1: Застийн газрын гадаад зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр дамжуулан зээлдүүлсэн зээлээс олон жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй 1.1 их наяд төгрөгийн авлагын үлдэгдэлтэй** | | |
| 1 | 1.Застийн газрын 19 байгууллагад олгосон 576.6 тэрбум төгрөг, 2.Төрийн емчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл 178.2 тэрбум төгрөг, 3.Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл 356.3 тэрбум төгрөг | | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлбарыг хавсралтаар хүргүүлэв. |
| 2 | **Асуулга 2 - Зөрчил 2,3-т заасан хүлээн зөвшөөрч бүртгэсэн ажил гүйлгээ, зөрчлийн шалтгаан тус бүрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, тайланг Төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр** | | |
| 2.1 | **Зөрчил -2: Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 256.3 тэрбум төгрөг /УУХҮС 234.6 тэрбум төгрөг, Сангийн сайд 12.0 тэрбум төгрөг, БХБС 3.1 тэрбум төгрөг, БШУС 1.9 тэрбум төгрөг, ХНХС 1.3 тэрбум төгрөг, ХХААХҮС 0.7 тэрбум төгрөг, ХЗДХС 0.6 тэрбум төгрөг, ОНБТСҮХ 0.3 тэрбум төгрөг, ЭМС 0.2 тэрбум төгрөг, МУЕП 0.2 тэрбум төгрөг, ЦХХХС 0.2 тэрбум төгрөг, Соёлын сайд 0.1 тэрбум төгрөг, ЗТХС 0.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.4 тэрбум төгрөг/** | | |
| 2.1 | **УУХҮС-234.6 тэрбум төгрөг** | | |
| 2.1 | Шивээ-Овоо ХК-177.5 сая төгрөг | Анхан шатны баримтад гүйцэтгэх захирлаар гарын үсэг зуруулж батлагаажуулаагүй. | Шивээ овоо ХК-ийн кассын гүйлгээгээр хийгдэж байгаа бэлэн мөнгөний дагалдах анхан шатны баримтууд болох мөнгө хүссэн өргөдөл, гүйцэтгэх захирлын тушаалтай буцалтгүй тусламж, сувиллын хөнгөлөлт, холбогдох байгууллагын нэхэмжлэл, томилолтын хуудас зэрэг баримтууд нь Гүйцэтгэх Захирлын бүрэн цохолттой боловч санхүүгийн программаас хэвлэгдэн гарч байгаа кассын зарлагын баримтыг Гүйцэтгэх Захирлын гарын үсэг зуруулаагүйгээс УАГ-аас 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн "Зөрчил арилгах тухай" 542/А0150118 дугаартай албан шаардлага өгсөн. Тус албан шаардлагын дагуу Шивээ-Овоо ХК-ний зүгээс 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 3/748 дугаартай албан бичгээр зөрчлийг арилган, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлсэн талаарх биелэлтийг хүргүүлсэн. |
| 2.1 | Эрдэнэс Оюу Толгой ХХК-40.9 сая төгрөг | Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ И баримтыг авааагүй. | 20 иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ тухайн байгууллагын нэр дээр и-баримтыг бүрдүүлэн авч хэвшүүлсэн. |
| 2.1 | Эрдэнэс Алт Ресурс ХХК-9.4 сая төгрөг | Мөнгөн хөрөнгийн ажил гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгахад 9.4 сая төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн баримт гаргуулан авааагүй байна. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж анхан шатны баримт, и-баримт бүрдэлтэд анхааран ажиллаж байна. |
| 2.1 | УУХҮЯ-6 8 сая төгрөг | Баримтын бүрдэл дутуу байхад ажил гүйлгээ хийсэн. | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу компаний өдөр тутмын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдөж, ил тод байдлыг хангаж, үр ашгийг нэмэгдүүлэн, үрэлгэн байдлыг хязгаарлан алдаа зөрчлийг дахин гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллаж байна. 2023 онд дутуу баримтуудыг нөхөн бүрдүүлсэн. |
| 2.1 | **Сангийн сайд-12.0 тэрбум төгрөг** | | |
| 2.1 | Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл-11,611.1 сая төгрөг | Дамбадаржаа болон Баянхошуу дэд төвүүдийн бүтээн байгуулалтын барилга угсралтын ажилд зориулан Нийслэлийн ЗДТГ-аас хөрөнгө оруулалтаар төслийн нэгж рүү 11.6 тэрбум төгрөгийг шилжүүлсэн бөгөөд үүнд аудитаар И-Баримт шивэх тухай зөвлөмж өгсөн. | Нийслэлийн засаг даргын тамгын газар нь төсөвт байгууллага тул И-баримт шивдэггүй учраас ажил гүйлгээний нөхөн бүртгэл хийгдээгүй байна. |
| 2.1 | **БХБС-3.1 тэрбум төгрөг** | | |
| 2.1 | Цемент шохой ТӨХК-3.1тэрбум төгрөг | Тайлант хугацаанд менгөн хөрөнгийн орлого зарлагын гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгахад 875.6 сая төгрөг, бараа материал 2,192.6 сая төгрөгийн ажил үйлчилгээний худалдан авалт нь төлбөрийн и-баримтаар баталгаажаагүй байна. | 2023 он хүдалдан авалт хийхдээ харилцагч байгууллагаар төлбөрийн нэхэмжлэх үүсгүүлж төлбөр төлсний дараа нэхэмжлэлийг төлбөр баримт болгоогүй улмаас тус зөрчил илэрсэн бөгөөд 2024 онд нэхэмжлэхийг төлбөрийн баримт болгосноор он дамжин зөрчлийг арилгасан. |
| 2.1 | **БШУС-1.9 тэрбум төгрөг** | | |
| 2.1 | БЕГ - 91 зөрчил 555.6 сая төгрөг | Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 555.6 сая төгрөг / ЕБС-ийн 46 зөрчил 194.7 сая төгрөг, СӨББ-ын 43 зөрчил 359.0 сая төгрөг, МББ-ын 1 зөрчил 1.5 сая төгрөг, НТББ-ын 1 зөрчил 0.2 сая төгрөг/. | Боловсролын сургалтын байгууллага улсын .хэмжээнд 2450 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэн Төсвийн төлөрүүлэн захирагч БЕГ нэгтгэн тайлагнадаг. Үүнээс 90 байгууллага буюу нийт байгууллагын 3.7 хувь нь энэхүү анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй гэсэн дүгнэлт авсан нь нэгж байгууллагын хувьд дундажаар 6.1 сая төгрөг нөгдөх хэмжээний материаллаг зөрчил байна. Салбарын хувьд орон нутагт цалин хөлс хангалттай бус учир мэргэжлийн нягтлан бодогчийн нөөцийн дутагдалтай, одоо ажиллаж байгаа хүмүүсийг чадавхижуулах зайлшгүй шаардлага үүссэр байна. Аудитын тайлангийн дагуу Боловсролын ерөнхий газраас 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 01/2029 тоот албан бичгийг харьяа байгууллагуудад хүргүүлж нэгдсэн чиглэл өгч ажилласан. 2024 оны 10 дугаар сард Боловсролын яамнаас салбарын аймаг, дүүргийн мэргэжилтэнгүүдэд нягтлан бодох бүртгэлийн чадавхи бэхжүүлэх сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. |

| Асуулга | Зөрчлийн агуулга | Зөрчил үүссэн тайлбар | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|
| | | | Энэхүү зөрчлийг арилгахаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд: |
| 2.1 | ХААИС - 1 зөрчил 639.3 сая төгрөг | ХААИС-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр "Мөнгөн зарлагын ажил гүйлгээг анхан шатны баримтруу тулган шалгахад баримт бүрдэл дутуу, цахим төлбөрийн баримтгүй 639.3 сая (Агро экологийн сургууль-55.5 сая төгрөг, Захиргаа аж ахуй-411.3 сая төгрөг, Инженер технологийн сургууль-19.6 сая төгрөг, Мал аж ахуй биотехнологийн сургууль-25.5 сая төгрөг, Мал эмнэлгийн сургууль-38.9 сая төгрөг, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль-11.8 сая төгрөг, Эдийн засаг бизнесийн сургууль-53.6 сая төгрөг) төгрөгийн ажил гүйлгээ бүртгэлд тусгасан" зөрчилд зөвлөмж авсан. | 1. ХААИС нь нийт 2 байранд 141 багш ажилчид ажилчдын орон сууцанд амьдардаг, орон сууцны 100 гэрээг шинэчилсэн.<br>2. 59 0 сая төгрөгийн тооцоо нийлсэн актыг нөхөн бүрдүүлсэн.<br>3. 274.2 сая төгрөгийн хаагдаагүй албан томилолтын 273.4 сая төгрөгийн баримтыг бүрдүүлэн тооцоо нийлж хаасан.<br>4. 119.1 сая төгрөг бүхий төлбөрийн баримт шивээгүй ААН-ийн 105.8 сая төгрөгийн төлбөрийн баримтыг нөхөн шивүүлсэн.<br>5. Бөөн дүнгээр шивсэн байсан 3.6 сая төгрөгийн гүйлгээний баримтыг задалж шивүүлсэн.<br>6. Баримтын бүрдэл дутуу 183.4 сая төгрөгийн баримтаас 165.3 сая төгрөгийн баримтыг бүрэн болгож алдаануудыг залруулан ажиллаж байна. |
| 2.1 | ШУТС - 1 зөрчил 189.4 сая төгрөг | Тайлант онд хаасан 32 төслөөс 7 төсөл анхан шатны баримтын бүрдэл дутуу, 2 төсөл үйл ажиллагааны чиглэл өөр компаниар ажил гүйцэтгүүлсэн, 3 төсөл зардлын дээд хязгаараас хэтрүүлсэн нийт 189.4 сая төгрөгийн зөрчилтэй гарсан. | Аудитын зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөө гарган ажиллаж, тухайн төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудад аудитын шалгалтаар илэрсэн зөрчилийг дахин давтаж гаргахгүй байх, төслийн удирдагч, санхүүгийн ажилтнуудад цаашид санхүүгийн алдаа гаргахгүй ажиллах талаар зөвлөгөө өгч ажиллаж байна. |
| 2.1 | Нийслэлийн боловсролын газар - 1 зөрчил 124.1 сая төгрөг | Тайлант хугацаанд цахим Е баримтын дүнгээс зөрүүтэй төлбөр шилжүүлсэн /баримтын бүрдэлийг ханган ажиллаагүй/. Өнөших трейд ХХК 57.7 сая төгрөг, Титэм тэнгэр ХХК 66.4 сая төгрөгийн төлбөрийн баримт үүсгээгүй байсныг нөхөн үүсгүүлсэн. | Өнөших трейд ХХК, Титэм тэнгэр ХХК төлбөрийн баримтын и-баримтын системд нөхөн үүсгүүлсэн. |
| 2.1 | Археологийн хүрээлэн - 1 зөрчил 101.1 сая төгрөг | ШУТС-аас санхүүжсэн нийт 7 эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төслийн 101.1 сая төгрөгийн үр дүнгийн тайлан, гүйцэтгэлийн баримт бичгийн бүрдэл дутуу байсан. | ШУТС-аас хэрэгжиж байгаа нийт 7 төсөл нь суурь судалгааны 1, гадаадтай хамтарсан 1, үндсэн чиглэлийн санхүүжилтийн төслүүд 2023 оноор дуусгавар болсныг 2024 оны 4 сарын 25-ны байдлаар ШУТС-тай үр дүнгийн болон санхүүгийн тайлангийн тооцоог хийж батлагаажуулан ажилласан. Эдгээр төслүүдийн анхан шатны болон НББ баримтыг архивлан бэлэн болгосон ба суурь судалгааны 3 төсөл, захиалгат 1 төсөл нь 2024 оны эцсээр дуусгавар болох бөгөөд жилийн эцсийн тайлангаар тооцоо нийлж баримтыг архивлан хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна |
| 2.1 | **Бусад байгууллага - 14 зөрчил 170.5 сая төгрөг** | | |
| 2.1 | Монгол улсын их сургууль - 48.9 сая төгрөг | Барилгын ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын (БУА-44/2023) дүгаар бүхий дүгнэлтээр хүлээн авсан боловч барилга орлогод авсан нь бүртгэлээр нотлогдоогүй. | Барилга, байгууламжийг хөрөнгийн орлогод бүртгэх зөвлөмжийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт санал хүргүүлэн зохих журмын дагуу шийдвэр гаргуулахаар ажиллаж байна. |
| 2.1 | Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль - 45.3 сая төгрөг | Хангамж үйлчилгээний газрын зарцуулсан шатахууны тооцоог анхан шатны баримтгүй зардлаар хүлээн зөвшөөрч, нягтлан бодох бүртгэлд тусгасан, анхан шатны баримтын бүрдэл дутуу, баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн. | 2023 онд АШУҮИС-ийн 3 сургуулийн хөтөлбөрийг ОУ-ын байгууллагаар мөнгөдлөн итгэмжлүүлсэн. Уг үйл ажилгагатай холбоотойгоор төлөвлөгдөөгүй зардлууд гарч байсантай холбоотойгоор гарсан зөрчлүүдийг дахин давтан гаргахгүй, холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаж байна. АШУҮИС нь автомашин ашиглахдаа шатахууны тооцоог бэлэн бусаар бүюу картаар хийж, тайлант хугацаанд гарсан зөрчлийг залруулан, жолоочийн замын хуудас болон холбогдох анхан шатны баримтыг нөхөж бүрдүүлсэн. 2024 онсос жолоочийн хариуцлагын гэрээг байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. |
| 2.1 | Монгол Улсын консерватори - 34.8 сая төгрөг | Нэр бүхий 4 байгууллагатай байгуулсан ажил гүйцэтгэх нийт 24.4 сая төгрөгийн гэрээг дүгнэсэн акт үйлдээгүй, урсгал засварт зарцуулсан 10.0 сая төгрөгийн гүйцэтгэлийн тайлан гаргаагүй байна. | Нэр бүхий 4 байгууллагатай байгуулсан ажил гүйцэтгэх нийт 24.4 сая төгрөгийн гэрээнд гэрээ дүгнасэн актыг нөхөж үйлдсэн ба 10.0 сая төгрөгийн гүйцэтгэлийн тайланг нөхөж үйлдсэн болно. 2024 онд гэрээгээр хийгдсэн ажлуудад гэрээг дүгнэн акт үйлдэж байгаа. |
| 2.1 | Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургууль - 8.0 сая төгрөг | Анхан шатны бүрдэл дутуу /и-баримтгүй/ 8.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна. | 2023 оны 1 сард Дэлхэ фүүдс ххк ийн гэрээг борлуулагч О.Төмөрсүхээс хүнсний бүтээгдэхүүн авсан худалдан авалтын и-баримтыг шивж өгөөгүйн улмаас гэрээ цуцалсан. |
| 2.1 | Цемийн физикийн судалгааны төв - 8.0 сая төгрөг | 2023 оны 8 дугаар сарын 28-30-ны хооронд зохион байгуулсан ОУ-ын эрдэм шинжилгээний хурлын зардал болох 8.0 сая төгрөгийн зардал анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. | Монгол улсын засгийн газрын 250 дугаар тогтоолын дагуу Академич Содномын мэндэлсний 100 жилийн ойд зориулсан "Рентген шинжилгээ" олон улсын эрдэм шинжилгээний зургаадугаар хурлыг 2023 оны 8-р дугаар сарын 28-30 хооронд зохион байгуулсан. Уг хурлын зардал болох 8.0 сая төгрөгний санхүүжилт нь 2023 оны 12 дугаар сард нэмэлт санхүүжилтийн дансанд орж ирсэн тул уг хурлыг зохион байгуулах санхүүжилтийг МУИС-ийн Эрдэм шинжилгээ инноваци нэгжтэй урьдчилан санхүүжүүлэх гэрээ байгуулан ОУ-ын хурлыг зохион байгуулсан. Уг хуралтай холбоотой анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэн ажилласан. Монгол улсын их сургуулийн 2023 оны 05 сарын 22-ны өдрийн А/220 дугаартай захирлын тушаал, ЦФСТевийн захирлын 2023 оны 12 сарын 12-ны өдрийн А/49 дугаар тушаал, 2023 оны 07 сарын 26-ны өдөр МУИС-Эрдэм шинжилгээ инновацын нэгжтэй байгуулсан "Олон улсын эрдэм шинжилгээний хурлын зохион байгуулалтыг урьдчилан санхүүжүүлэх гэрээ". Хурлын удирдамж, хөтөлбөр зэргийг үндэслэсэн байна. 2024 оны 3-р улирлын байдлаар Олон улсын хурал зохион байгуулаагүй бөгөөд дээрх хурлын зардалтай ижил төстэй хурлын зардал НББ-ээр бүртгэгдээгүй байна. |
| 2.1 | **ХНХС-1.3 тэрбум төгрөг** | | |
| 2.1 | **ХХҮЕГ болон харьяа байгууллага-130.8 сая төгрөг** | | |
| 2.1 | Баянзүрх дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс 1.0 сая төгрөг | Нэг удаагийн тэтгэмжийн зардлаас түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо анхан шатны баримт дутуу бүрдүүлсэн | Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. |
| 2.1 | Баянзүрх дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс 6.6 сая төгрөг | Мөнгөн хөрөнгийн зарлага, ерөнхий журнал болон анхан шатны бариттай тулган баталгаажуулахад 6,616.30 мянган төгрөгийн 1 баримт анхан шатны баримт бүрдэл дутуу байна. | Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг ханган анхан шатны баримтыг нөхөн бүрдүүлсэн. |
| 2.1 | Говьсүмбэр аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 0.4 сая | Бараа материалын тайлан, анхан шатны баримтуудтай танилцахад агуулахын бүртгэл хөтөлдөггүй, зарим баримтын гарын үсгийн баталгаажуулалт дутуу, жолоочийн тооцооны хүснэгтийг 5-9 сард тухай бүрд холбогдох зааврын дагуу хөтөлж, тооцоог бүрэн мөрдөөгүй зөрчил илэрсэн. | Агуулахын бүртгэлийг хөтөлж, хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүрд хийж, ажиллаж байна. Бараа материалын тайлан, анхан шатны баримтын бүрдлийг ханган, баримтын гарын үсгийн баталгаажуулалтыг бүрэн хийж ажиллаж байна. Жолоочийн тооцооны хуудсыг журмын дагуу бүрэн хөтөлж, ажиллаж байна. |

| Асуулга | Зөрчлийн агуулга | Зөрчил үүссэн тайлбар | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|
| 2.1 | Орхон аймгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар 3.4 сая төгрөг | Цалингийн зардлыг цалингийн журналаас анхан шатны баримт руу хөөн шалгахад 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, үр дүн харгалзан олгосон мөнгөн урамшууллыг 3,411,263 төгрөгөөр илүү олгосон байна. | Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот дансанд 2024.05.17-ний өдөр төвлөрүүлэв. |
| 2.1 | Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газар 10.1 сая төгрөг | Тайлант онд анхан шатны баримтын бүрдэл дутуу хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээг хийж зардлаар бүртгэж тайлагнасан.( шаардах хуудас дээр дарга, нягтлан бодогчийн зөвшөөрөл цохолтгүй,хүлээн авсан хүний гарын үсэг дутуу байхгүй,агуулахын бүртгэл хөтлөөгүй 10,138.0 мянган төгрөг) | Ажилчдаас албан ажлын хэрэгцээнд ашиглахаар бараа материал хүссэн тухай бүр нь шаардах хуудсыг бичүүлж эрх бүхий албан тушаалтнуудаар баталгаажуулсныг үндэслэн шаардлагатай материалыг олгож хэвшсэн. Цаашид ийм алдаа зөрчил гаргахгүй байхад анхааран ажиллаж байна. |
| 2.1 | Орхон аймгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар 3.7 сая төгрөг | Гэрээ тус бүрээр мөнгөн хөрөнгийн журналаас анхан шатны баримт руу хөөн шалгахад 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан 04 дугаартай 3,754,800 төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээний төлбөрийг ажил гүйцэтгэж дууссан хүлээлгэж өгөөгүй байхад урьдчилан шилжүүлсэн байна. | Ажлын төлөвлөгөө гарган батлуулж 3ХХ-ийн дарга Г.Гансүх хариуцан гэрээний дагуух ажлыг Өмч хамгаалах комисс хүлээн авч тайланг санхүүгийн баримтад хийж баталгаажуулсан. |
| 2.1 | Орхон аймгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар 0.8 сая төгрөг | Анхан шатны баримтын бүрдэл хангалттай бөгөөд хүчин төгөлдөр эсэхийг анхан шатны баримт руу хөөн шалгахад худалдан авч орлогоор бүртгэсэн бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, үнийн дүн цахим төлбөрийн баримтад нийт дүнгээр бүртгэсэн байна. | Худалдан авсан бараа ажил үйлчилгээний тоо хэмжээ, бараа материалыг нэр төрлөөр нь шивүүлэн нэхэмжлэл үүсгүүлэн цахим системд бүртгүүлэн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Баримт болгон Харилцагч байгууллага болох Маамуу электроникс ХХК-65500 ₮, Оттонсүх-100.000 ₮, Ар өврийн үндрам -652 300₮ гэх мэтчилэн байгууллагын нэхэмжлэхийн баримтыг хавсаргаж, 2024 оны 5 сарын 17-ний өдрийн 01/462тоот албан бичгээр хүргүүлсэн байгаа. |
| 2.1 | Орхон аймгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар 0.7 сая төгрөг | Батлагдсан төсвийн хүрээнд гарсан зардлыг мөнгөн хөрөнгийн журналаас анхан шатны баримтлуу хөөн шалгахад Ахлах мэргэжилтэн, нягтлан бодогч нарт 753,298 төгрөгийн балансын урамшууллыг илүү олгосон байна. | Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот дансанд 2024.05.17-ний өдөр төвлөрүүлэв. Төлбөрийн баримт хавсаргав./ 3 актны нийлбэр дүнгээр/ |
| 2.1 | Орхон аймгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар 0.06 сая төгрөг | Төсөл, хөтөлбөрийн зарцуулалтыг зориулалт тус бүрээр мөнгөн хөрөнгийн журналаас анхан шатны барим руу хөөн шалгахад байгууллагын удирдлага тушаал гарган өөртөө 60,000 төгрөгийн шагнал олгосон байна. | Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот дансанд 2024.05.17-ний өдөр төвлөрүүлэв. Төлбөрийн баримт хавсаргав. / 3 актын нийлбэр дүнгээр/ |
| 2.1 | Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс 11.6 сая төгрөг | Зарим төсөл, хөтөлбөр арга хэмжээнд гүйцэтгэлийн тайлангүй, гэрээ дүгнэсэн актгүй, судалгааны ажлын батлагдсан төсвийн хуваарилалтыг өөрчлөж олгосон, зөвлөх хариуцагчийн дансаар дамжуулан бүртгэгүй зөрөг 11,580.0 мянган төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу, баримтаар гүйцэтгэж хийж зардалд тусгасан. | Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн энэ онд алдаа давтан гаргахгүй ажиллаж байна. Засвар үйлчилгээ хийхдээ техникийн акт үйлдэж фото зургаар баталгаажуулж, гэрээг тухай бүр дүгнэж, хэмнэлтийн хууль хэрэгжүүлэн ажиллаж байна. |
| 2.1 | Сонгинохайрхан дүүргийн Халамжийн сан 47.6 сая төгрөг | Бараа материалын тайланг нэр төрлөөр тайлагнаагүй (шатахуун, бичиг хэрэг ) 46,936.0 мянган төгрөг, зөвлөх хариуцагчийн тайлан нь гар бичмэлээр баллаж, цохолсон дүгнэж нэгтгээгүй, анхан шатны баримтын шаардлага хангаагүй, шатахуун зарцуулалтын тайланг анхан шатны баримт болон дансны журналын бичилттэй тулган шалгахад 694.3 төгрөгөөр зөрүүтэй байна. | 2024 оны бараа материалыг нэр төрөл тус бүрээр нь салгаж бүртгэсэн. Бараа тус бүрээр дүгнэж нэгтгэн анхан шатны баримт, бараа материалын тайланг батлагдсан маягтаар засваргүй тайлагнасан. |
| 2.1 | Сонгинохайрхан дүүргийн Халамжийн сан 23.6 сая төгрөг | Нэмэлт санхүүжилтээр хэрэгжүүлсэн зарим төсөл хөтөлбөр арга хэмжээний төсвийн зарцуулалтын болон гүйцэтгэлийн тайлангүй, гэрээ дүгнэсэн актгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж зардалд тусгасан. | Нэмэлт санхүүжилтээр хэрэгжүүлсэн зарим төсөл хөтөлбөр арга хэмжээний төсвийн зарцуулалтын болон гүйцэтгэлийн тайлан, гэрээ дүгнэсэн акт, анхан шатны бүрдэл бүрэн авч байгаа. |
| 2.1 | Хөвд аймгийн Халамжийн сан 6 сая төгрөг | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөл олголтын анхан шатны баримтуудаас үзэхэд төсөл тус бүрийг үнэлж хэлэлцээгүй, хяналт хангалттай түвшинд хэрэгжүүлэлгүй олгосон байна. | ОНӨТХУ-ний Бүлгийн төсөлд 2023 онд аймгийн хэмжээнд нийтдээ 533 бүлгийн 1066 иргэн хамрагдсан байна. Үүнээс жаргалант сумын 267 бүлгийн төсөлд хяналт хийлээ. Захиргаа хяналтын хэлтсийн хяналтын төлөвлөгөөний дагуу Дуут, Хөвд, Үенч, Булган сумдад газрын даргаар удирдамж батлуулан бүлгийн төсөлд хамрагдсан иргэдийн төслийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг зохион байгуулсан байна. |
| 2.1 | Архангай аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний 8.7 сая төгрөг газар | Цалин, нэмэгдэл, урамшууллыг зохих хууль, журмын дагуу олгож байгаа эсэхийг цалингийн анхан шатны баримтаар тулган шалгахад тайлант онд 1116817,6 мянган төгрөгийн цалингийн зардал гаргасан байна Цалингийн зардлыг тулган шалгахад тус газрын даргын 2023 оны 06 сарын 16-ны өдрийн Б/38, 2023 оны 12 сарын 18-ны өдрийн А/56 дугаар тушаалуудаар ажилчдын хагас бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ үнэлгээний багийн ажил дүгнэсэн үнэлгээнд үндэслэн урамшууллыг олгоогүй цалингийн санд багтаан хэвтгайруулан олгосонтой холбоотой 8711.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. | Алдаа зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан . Ажиллагдын хагас бүт |
| 2.1 | Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс 1.5 сая төгрөг | Тайлант онд бодож олгосон цалингийн зөрүүгийн тооцоолол буюу нэмж олгосон цалингийн анхан шатны баримт байхгүй./1,452.0/ | 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр А.Сэрээтэрийн цалингаас 600000.00 төгрөгийг НТАГ-хүү орлогын 100200000908 тоот дансанд шилжүүлсэн.Үлдэгдэл 2024.оны 05 дугаар сарын 24-ны өдөр А.Сэрээтэрийн цалингаас 852.000 төгрөгийг суутгасан жагсаалтын дагуу НТАГ-хүү орлогын 10020000908 тоот дансанд албан хаагчдаас суутгасан суутгал 4236000 төгрөгийн жагсаалтад орсон. |
| 2.1 | Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс 5 сая төгрөг | Тайлант онд зохион байгуулсан сургалтын анхан шатны баримтын дутуу ажил гүйлгээ зардлаар бүртгэж тайлагнасан./4,992.0/ | 4992.0 төгрөгийн зардал баталгаажсан зардал зөрүү 8.0 төгрөгийг шилжүүлсэн баримт нь байгаа.2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Хөдөлмөрийн АБЭМТөвийн 9081488 регистртэй 1009000037404 тоот дансанд сургалтын зардлын үлдэгдлийг шилжүүлсэн. |
| 2.1 | **Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгаалллын яам- 462,5 сая төгрөг** | | |

| Асуулга | Зөрчлийн агуулга | Зөрчил үүссэн тайлбар | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|
| 2.1 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалллын яам 462.5 сая төгрөг | "1. Тайлант онд нийт 305,304.0 мянган төгрөгийн сургалт, хурал зөвлөгөөн, хэлэлцүүлэг арга хэмжээ зохион байгуулсан ажлын тайлан, гэрээ дүгнэсэн актүүд, гадаад албан томилолтын 79,697.9 мянган төгрөг, гараашны хаалганы засварын 6,767.7 мянган төгрөг. ХНХЯ-ны ТНБД-ын 2023 оны А/36, А/204-р тушаалаар 110 ахмадын хүндэтгэлийн арга хэмжээнд 17,390.0 мянган төгрөгийн бэлнээр олгосон урамшууллын анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллаагүй байна. 2. Үндсэн хөрөнгийн данснд бүртгэлтэй 4 авто тээврийн хэрэгсэлд тушаал шийдвэр, ӨХБЗ болон техникийн комиссын дүгнэлтгүй нийт 53,321.6 мянган төгрөгийн засвар үйлчилгээ хийсэн байна." | НҮБ-ын хүүхдийн сангаас Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үндэсний сургагч багш бэлтгэх, тэгш боломжын төлөө залуучуудын манлайлал 267.4 сая төгрөг,ОУлсын хөдөлмөрийн байгууллагаас ХНХЯамны салбарын хяналтын улсын байцаагчдыг чадавхжуулахад сургалт 66,2 ХБХЭМНХ гишүүдийг чадавхжуулах сургалт 37,2сая төгрөгийн сургалтын санхүүжилт батлагдаж яамны нэмэлт төсвийн дансаар зарцуулагдсан. Хөдөө орон нутгийн байцаагч нар мэргэжилтэнүүдийг зайлшгүй танхимын сургалтанд хамруулах шаардлагатай байдаг ХНХЯамны ТНБД -ын 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/71 техникийн комисс байгуулах тухай тушаал гарсан. Тушаалын дагуу техник хэрэгсэлд дүгнэлт үйлдэн засвар үйлчилгээ хийсэн. Мөн анхан шатны баримтын бүрдлийг ханган ажилласан. |
| 2.1 | ХЭДС болон харьяа байгууллага-213.9 сая төгрөг | | |
| 2.1 | Багануур дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 1.9 сая төгрөг | Өдөрлөгийн арга хэмжээнд анхан шатны баримтүүй шатахууны зардлыг данс бүртгэлд тусгасан | Жолоочийн тооцооны хуудсыг тухай бүр журмын дагуу бүрэн хөтөлж, гарын үсгийн баталгаажуулалтыг хийж, бичиг баримтын бүрдлийг ханган ажиллаж байна. |
| 2.1 | Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 28.0 сая төгрөг | Авлага барагдуулалтыг санхүүгийн тайлангийн тодруулга, ерөнхий дэвтэр, журналаас анхан шатны баримт руу хөөн шалгахад 2023 оны жилийн эцсийн байдлаар 297 иргэнтэй холбоотой нийтдээ 655,522.2 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн хөнгөлөлттэй зээлийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнээс 282 иргэнтэй холбоотой 637,489.7 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн хөнгөлөлттэй зээлийн авлагыг барагдуулахаар хууль хяналтын байгууллагад 2018-2023 онд шилжүүлсэн байна. Мөн нас барсан 11 иргэний 24,802.5 мянган төгрөгийн, хариуцагч нь сураггүй болсон 4 иргэний 3,230.0 мянган төгрөгийн зээлийн авлага байна Дээрх хугацаа хэтэрсэн хөнгөлөлттэй зээлийн авлагын үлдэгдэл баталгаатай эсэх нь тодорхой бус, үлдэгдэл нь баталгаажаагүй байна. | Аймгийн аудитын газраас 2023 онд хийгдсэн тайлангийн аудитаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авч төлөх хугацаа хэтэрсэн авлага болох зээлдэгч нас барсан, сураггүй алга болсон 15 иргэний 28.0 сая төгрөгийн төлбөрийг барагдуулах албан шаардлагыг хүргүүлсэн бөгөөд үүний мөрөөр арга хэмжээ авч ажиллаж хуулийн байгууллагад шилжүүлсэн. Үүнээс нас барсан 11 иргэний төлбөр болох 24.8 сая төгрөгөөс 6.3 сая төгрөгийг ар гэр нь төлж барагдуулсан бөгөөд 6 иргэний 10.3 сая төгрөгийг төрүүлэх талаар шүүхийн байгууллагаас шийдвэр гарч гүйцэтгүүлэх шатанд байна. Батлан даагч болон зээлдэгч нь хөөцөлдөх нас барсан 4 зээлдэгчийн 7.6 сая төгрөгийг шүүхээс төлөх боломжгүй болохыг тогтоон шийдвэр гаргасан. Сураггүй алга болсон 4 иргэний 3.8 сая төгрөгийн нэхэмжлэлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн болно. |
| 2.1 | Баянгол дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 31 сая төгрөг | Хүүхэд хамгаалагч үйлчилгээнд хамрагдсан ахмадуудын урамшуулалд анхан шатны баримт хангалтүй, хамаарал бүхий бусад байгууллагуудаар баталгаажуулаагүй баримтаар 30,884.0 мянган төгрөг олгосон. | Хүүхэд хамгаалагч төслийн хүрээнд хийгдэж байгаа 4 талт гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах хүсэлтийг дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хандан хамтран ажиллаж байна. Хүүхэд хамгаалагч төслийн хүрээнд хийгдэж байгаа 4 талт гэрээний хэрэгжилтийг хангах, сайжруулах үүднээс хяналт тавьж ажиллах хүсэлтийг дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хандан хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж буй ахмадуудын гэмт хэргээс сэргийлэх ажил байршилд хяналт тавиулж, сар бүр тайлан гаргуулан авч хамтран ажиллаж байна. |
| 2.1 | Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 4.5 сая төгрөг | тайлант онд санхүүжүүлсэн хөтөлбөр арга хэмжээнүүдийг мөнгөн хөрөнгийн журнал, гэрээ, хэлцэл, анхан шатны баримт руу хөөн шалгахад 4500000 төгрөгийн баримт дутуу гаргасан. | 2024 онд түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдах хүсэлт гаргасан иргэдийг төлбөр төлсөн баримтаа татварын И баримтаар баталгаажуулах шаардлага тавин ажиллаж байна. Одоогоор түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийн зардал гараагүй байна. |
| 2.1 | Налайх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 97.8 сая төгрөг | Тайлант онд тус байгууллага нь ажил эрчимжүүлэх төлөвлөгөө гаргаж ажилласны үр дүнд анхан шатны баримтын бүрдэл, шалгуур үзүүлэлт хангагүй зээл гаргаагүй байлаа. Гэвч Эргэн төлөгдөх нөхцөлтэй өгсөн зээл, зээлийн хүүгийн авлагуудыг барагдуулаагүй, хугацаа хэтэрч шүүх рүү шилжсэн 97,834,800 төгрөгийн авлага байна. | Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн хугацаа хэтэрсэн авлагаас 8 сарын 28-ны өдрийн байдлаар 41,796,325 төгрөг төлөгдсөн байна. Хугацаа хэтрэлтэй байгаа нийт 33 иргэнээс 17 иргэн бүрэн төлж дууссан. Үлдсэн 16 иргэний зээлийг бүрэн төлүүлэхээр тухай бүр төлөвлөгөө гаргаж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэстэй хамтран ажиллаж байна. |
| 2.1 | Налайх дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс 4.2 сая төгрөг | Шатахууны тайланд холбогдох анхан шатны баримтыг бүрэн хөтөлсөн олгогдсон талоны нийт дүнгээр шаардах хуудсыг бичсэн байна. | Тус байгууллагын санхүүгийн програмд шатахууны орлого, зарлагыг бүртгэхдээ хэмжих нэгжийг нь литрээр оруулан хөтөлж байна. |
| 2.1 | Сүхбаатар аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 5.4 сая төгрөг | Сургалтыг анхан шатны баримтаар тулган баталгаажуулахад сургалтын хөтөлбөр, суурь сургалт зохион байгуулах гэрээ, сургалтын ирцийн бүртгэл, сургалт зохион байгуулсан тайлангаар хэд хоногийн сургалт явуулсан хугацаа тодорхойгүй /зөрүүтэй/, сургалтын гэрээг дүгнэж акт үйлдээгүй, сургалтын ирцийн бүртгэл дутуу, сургалт явуулсан талаарх зураг, дүрсжүүлсэн бичлэг гэх мэт иж бүрэн нотлох баримтаар дэмжигдээгүй байна | 2024 онд хөдөлмөр эрхлэлтийн суурь ур чадвар олгох, мэргэжлийн ур чадвар олгох сургалтыг явуулах эрх авсан 9 байгууллага материалаа ирүүлснийг ажлын хэсгээр судлан үзэж, хэлэлцэн "Сонор едукейшн", Мөнх алтан хүлэг, Сүхбаатар МСҮТ, сургалтын төвийг сонгон шалгаруулаа.ААЭ-ийн сургалт, АМЧБО бүлгийн болон ганцаарчилсан сургалт, суурь ур чадвар олгох сургалтыг зохион байгуулж, сургалтын гэрээг сургалт дууссаны дараа хэрэгжиптийг дүгнэн гэрээ дүгнэсэн акт үйлдэж төлбөр тооцоог шилжүүлж ажиллалаа. |
| 2.1 | Сүхбаатар дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс 1.3 сая төгрөг | Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийсэн | Анхан шатны баримтын бүрдлийг ханган ажил гүйлгээг бүртгэж, ажил үйлчилгээний чанар, хэрэгжилтэд хяналт тавьж аудитын зөвлөмжийн дагуу анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ бүртгэлгүй зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан. 2023 онд дутуу бүртгэгдсэн 1,280,000 төгрөгийн И-баримтыг нөхөн шивүүлсэн. |
| 2.1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан 16.5 сая төгрөг | Монгол-Хятадын эксло 2023 үзэсгэлэн худалдааны оролцогчдын 16,500,000.00 төгрөгийн НББ-ийн анхан шатны баримтын бүрдэл дутуу | Хөгжлийн бэрхшээлтэй тэргэнцэртэй иргэдийн петаник спортын хороо 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөөс 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр хүртэл БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах 12 хүний бүрэлдэхүүнтэй үзэсгэлэн худалдаанд оролцож туршлага судалж ирсэн. Уг үйл ажиллагааны байр, үзэсгэлэнгийн лангууны төлбөрийг ХБХХЕГ-аас дэмжиж ажилласан бөгөөд анхан шатны баримтуудыг нөхөн бүрдүүлэн Аудитын байгууллагад хүргүүлэн биелэлтийг ханган ажилласан болно. |

| Асуулга | Зөрчлийн агуулга | Зөрчил үүссэн тайлбар | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|
| 2.1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 17.1 сая төгрөг | Тайлант онд төсөв захирагчийн тушаал шийдвэр, гэрээгүй 6,335.0 мянган төгрөгийн урсгал засвар үйлчилгээний зардалд зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу 10,777.0 мянган төгрөгийн зардал гаргаж бүртгэсэн байна. | Санхүүгийн анхан шатны баримтын иж бүрдлийг бүрэн хангах талаар албан шаардлагаар өгсөн заалтыг үйл ажиллагаандаа мөрдөж үүний хүрээнд төрийн сангийн данснаас зарлагын гүйлгээ хийхдээ санхүүгийн анхан шатны баримтын иж бүрдлийг бүрэн хангаж, тус ерөнхий газрын дарын тушаал шийдвэрийг үндэслэн хөрөнгө зарцуулах гүйлгээг хийж байна. Байгууллагын урсгал засвартай холбоотой зардлыг гаргахдаа хийгдэх ажлын даалгаврыг байр ашиглалтын инженер, нярваар урьдчилан бэлдүүлж холбогдох нэгжийн даргаас зөвшөөрөл авсны дараа зарцуулалтыг хийж хэвшсэн. 2023 онд байгууллагын засварт 16 удаагийн гүйлгээгээр 6,335.0 төгрөгийг зарцуулсанд бараа материал, ажлын хөлсийг нэхэмжлэхээр гаргаж ажил гүйцэтгүүлсэн. 2024 онд 5 удаагийн байгууллагын урсгал засвартай холбоотой зардлыг гаргахдаа хийгдэх ажлын даалгаврыг байр ашиглалтын инженер, нярваар урьдчилан бэлдүүлж холбогдох нэгжийн даргаас зөвшөөрөл авсны дараа зарцуулалтыг хийж хэвшсэн. 2023 оны анхан шатны баримтад бүрдэл дутуу зардал гаргасан баримтуудыг дахин нэг бүрчлэн шалгаж, холбогдох байгууллагуудаас зарлагын баримтуудыг авч нөхөн бүрдүүлэлтийг хийсэн. |
| 2.1 | Дархан аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 0.3 сая төгрөг | Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны зохион байгуулсан сургалтад хамрагдсан иргэдийн анхан шатны баримт, мэдээлэл хангалтгүй байгаагаас 8 иргэнд 320.0 мянган төгрөгийн санхүүжилт илүү олгосон. | Сургалт зохион байгуулсан байгууллагуудтай гэрээ дүгнэсэн акт, анхан шатны баримтыг мэргэжилтэн бүрдүүлэхэд жагсаалт гарган ХШҮ хариуцсан ахлах мэргэжилтэн хяналтын дүгнэлтэд үндэслэн зардлыг санхүүжүүлэхээр шийдвэрлэн аудитын зөвлөмжийн төлөвлөгөө гарган ажиллаж байна. Зөвлөмжийн дагуу Монголын ажил олгогч эздийн холбооны зохион байгуулсан сургалтад хамрагдсан 8 иргэний анхан шатны баримтын бүрдлийг гүйцэлт 320,000 төгрөгийн зөрчлийг арилгасан. Цаашид сургалтад хамрагдсан иргэдийн иргэний үнэмлэхний хуулаа, харъяалал, буртгэл, өргөдлийг хянан И Монголиа системийг ашиглан анхан шатны баримтын бүрдүүлэлтийг ханган ажиллаж байна. |
| 2.1 | Сүхбаатар аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 1.1 сая төгрөг | Тээвэр шатахуун зарцуулалтыг анхан шатны баримттай тулгахад жолоочийн тооцооны хуудсанд "Баруун-Урт сум дотор, хяналт үнэлгээний ажлаар, аж ахуйн нэгжүүдээр" агуулгаар хаана явсан нь тодорхойгүй 1,080.0 мянган төгрөгийг зарцуулжээ | Байгууллагын шатахууны карттай болж шаардах хуудсаар шатахууны картыг цэнэглэж, зарцуулалтын тайланг гарган ажиллаж байна. Тээвэр шатахууны зарцуулалтыг " сум дотор, хяналт үнэлгээний ажлаар, аж ахуй нэгж байгууллага, айл өрхөөр гэсэн ангуллаар хаана явсан тодорхойгуй бичсэн зөрчлийг дахин гаргахгүйгээр ажлаар явж бэйгаа албан хаагдаас шаардах хуудасны дагуу маршрут, зураглалыг гаргуулан авч зарцуулалтыг тооцож байгууллагын шатахууны картыг тухай бүр цэнэглэж, зарцуулалтын тайланг гарган зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж байна. |
| 2.1 | Говьсүмбэр аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 0.17 сая төгрөг | Тээвэр шатахуун тайланд 169.1 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан | Аудитын байгууллагаас 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн актын төлбөр болох 169,116 төгрөгийг 2024 оны 03 сарын 22 өдөр Говьсүмбэр аймгийн Төрийн аудитын газрын 100220000954 /Гүс.төсөөт байгууллагын өөрийн орлого/ тоот дансанд төвлөрүүлсэн. |
| 2.1 | Багануур дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 4.6 сая төгрөг | Сангийн зардлаар өдөрлөг зохион байгуулахдаа анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ зардалд тусгасан | Ажилчдаас албан ажлын хэрэгцээнд ашиглахаар бараа материал хүссэн хүсэлтийг тухай бүрд нь шаардах хуудсыг бичүүлж, эрх бүхий албан тушаалтнуудаар баталгаажуулсныг үндэслэн шаардлагатай материалыг олгож хэвшсэн. Цаашид ийм алдаа зөрчил гаргахгүй байхад анхааран ажиллаж байна. |
| 2.1 | ХГБХХЕГ, НД болон харьяа байгууллага-454.1 сая төгрөг | | |
| 2.1 | Баянзүрх дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс 8.7 сая төгрөг | Мөнгөн хөрөнгийн зардлыг, ерөнхий журнал болон анхан шатны баримттай тулган баталгаажуулахад 8654.5 мянган төгрөгийн е баримтгүй гүйлгээ хийсэн | НББ-ийн тухай хууль, холбогдох хууль журмын хэрэгжилт хангаж ажиллана.Сар бүр И баримтын тулгалтыг хийж ажиллаж байна. |
| 2.1 | Булган аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 1.6 сая төгрөг | Албан хаагчдад үндэслэл, анхан шатны баримтгүйгээр илүү цаг тооцон олгосон. | 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Булган.аудит-орлого төрийн сангийн 100040051005 дансанд 1,600.0 мянган төгрөгийн илүү цаг, 428.9 мянган төгрөгийн хоол нийт 2,028.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Актын төлбөрийг бүрэн барагдсан. |
| 2.1 | Налайх дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс 74.8 сая төгрөг | Албаны дарын тушаалаар мөнгөн хөрөнгө төсөвлөж үйл ажиллагаа явуулахдаа анхан шатны баримтын бүрдэлгүй, хийсэн ажлын гэрээ дүгнэсэн акт үйлдэгтүй, санхүүгийн хяналт маш сул. | 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтаар өгсөн албан шаардлагын дагуу дараах байгууллагуудтай гэрээ дүгнэсэн протоколыг нөхөн бүрдүүлсэн ажилласан. Үүнд: Бид тэд гэрэлт ертөнц ТББ -15,000,000, Мэргэшсэн орчуулагч редакторудын гарьд холбоо ТББ 19,850,000, Хүннү ложистик ХХК - 4,950,000, Универсал авто комплекс - 3,678,950, Номин ураг болор ХХК- 18,431,650, Элбэг арвин эрдэс ХХК - 12,900,000 төгрөг, 2024 онд анхан шатны баримтыг бүрэн гүйцэт бүрдүүлэн, тухай бүр гэрээ дүгнэсэн протокол үйлдэн ажиллаж байна. |
| 2.1 | Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 3.6 сая төгрөг | Анхан шатны баримтгүйгээр харилцахаас гүйлгээ хийсэн. Тухалбал. Шаардах, ажлын тайлангүй хичээлийн хэрэгсэл, цунх -1,600.0 мянга, жагсаалт, гарын үсэг тайлангүй сурагч цунх - 2,000 мянга гаргасан байна. | Тухайн байгууллагаас актын төлбөрийг гаргуулан авч төрийн сангийн данс болох 100200000908 тоот дансанд 3,600.0 мянган төгрөгийг хүүгийн торгуулийн орлогыг төвлөрүүлж ажилласан. |
| 2.1 | Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор 10.2 сая төгрөг | Хүнсний материал болон ажлын бэлэгийг орлогоор данс бүртгэлд тусгаагүй, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй. 10,201.2 мянган төгрөгийг шууд зардалд бүртгэсэн. | 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр төрийн сангийн 100900000601 дансанд 10201.8 мянган төгрөг төвлөрүүлсэн. Акт бүрэн барагдсан. |
| 2.1 | Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор 1.3 сая төгрөг | Жолоочийн тооцооны хуудасны стиометрийн зааалт бичигдээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй 1,300.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан | 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдөр төрийн сангийн 100900000601 дансанд 1300.0 мянган төгрөг төвлөрүүлсэн. Акт бүрэн барагдсан. |
| 2.1 | Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс 30 сая төгрөг | Мөнгөн хөрөнгийн гүйлгээг тулган шалгахад зарим төсөл арга хэмжээний төсөвийн зарцуулалтын болон гүйцэтгэлийн тайлангийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар 56,984.2 мянган төгрөгийн гүйлгээ хийж зардалд нь төсөв хяналтгүй зарцуулагдах үр дагавар бий болгосон | 2024 оны хагас жилийн байдлаар үндсэн санхүүжилтээр төсөл, хөтөлбөр, арга хэмжээ зохион байгуулах нийт 47 аж ахуй нэгж, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж үйл ажиллагаа зохион байгуулсан бөгөөд гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн зарцуулалтын тайланг хүлээн авч гэрээ дүгнэсэн акт, протоколыг үйлдэн ажиллаж байна. |
| 2.1 | Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын газар 62.2 сая төгрөг | Бүрдэл дутуу анхан шатны баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан | Холбогдох хууль тогтоомж болон Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу холбогдох бараа материал болон үйл ажиллагааны анхан шатны баримтыг нөхөн бүрдүүлэн ажилласан болно. |
| 2.1 | Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв 11 сая төгрөг | Анхан шатны баримтын бүрдэлгүй, нотлох баримтын шаардлага хангахгүй 10,964.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна. | Холбогдох хууль тогтоомж болон Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу холбогдох бараа материал болон үйл ажиллагааны анхан шатны баримтыг нөхөн бүрдүүлэн ажилласан болно. |

| Асуулга | Зөрчлийн агуулга | Зөрчил үүссэн тайлбар | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|
| 2.1 | Хүүхдийн төлөө сан 17 сая төгрөг | Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадам, олимпиадад амжилт гаргаж болзол хангасан 11 хүүхэд олгосон 17,000.0 мянган төгрөгийн шагнал урамшуулалд харьяалах байгууллага, мэргэжлийн холбооны тодорхойлолт хүсэлт ирүүлээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. | Хамтран ажилладаг байгууллагууд руу анхан шатны баримтад хавсаргах материалын жагсаалтыг хүргүүлж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах талаар Агентлагийн даргын 2024 оны 01/375 дугаартай албан бичгийг хүргүүлсэн |
| 2.1 | Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр 4.6 сая төгрөг | Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 101/ШШ2022/02852, 101/ШШ2022/04326 дугаар магадлалаар нэг ажилтанд 3,962.0 мянган төгрөгийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговор олгож, НДШ-ийн зардалд 602.0 мянган төгрөг, нийт 4,564.0 мянган төгрөг зарцуулсан байна. | Шийдвэр гарсасан албан хаагчид 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр 01/92 албан бичиг хүргүүлсэн. Нөхөн төлүүлэх арга хэмжээг авахаар ажиллаж байна. |
| 2.1 | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар 62.4 сая төгрөг | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж сургалт, хэлэлцүүлэг, арга хэмжээ зохион байгуулахад нийт 62,439.4 мянган төгрөгийн томилолтын зардал зарцуулсан, ажлын тайлан анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. | Монгол Улсын Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02 өдрийн "Дотоод албан томилолтын зардлыг хэмнэх шинэчлэн батлах тухай" А/120 дугаар тушаал үндэслэн албан томилолтоор явж байгаа албан хаагчдаас тухай бүр ажлын тайланг авч үр дүнг тооцож ажиллаж байна.Жишээ нь:Тус сургалтыг зохион байгуулахад 21 аймгийн албан хаагчдын томилолт 100 гаруй хүн тус томилолтын зардлыг НҮБ-ын Хүүхдийн сангаас гаргасан. Үүнд: Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS6948:2021 стандарт сургалтыг ХНХЯ-наас 2022 онд зохион байгуулсан ба тус үйл ажиллагааны үргэлжлэл болгож ЗГХА Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас НҮБ-ын Хүүхдийн сангаас 72,664,644 төгрөгийн санхүүжилтээр "Гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал" арга зүйн зааварчилгаа өгөх арга хэмжээ, бэлтгэл сургуулилтыг Агентлагийн даргын 2024оны А/80, А/87 дугаар тушаалаар тус зохион байгуулсан бөгөөд тухай бүр орон нутагт ажилсан албан хаагчдаас томилолтын хуудас, ажлын тайлауулаагүй бөгөөд дээрх хүрлын зар |
| 2.1 | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар 165.2 сая төгрөг | Анхан шатны баримтын бүрдэлгүй, нотлох баримтын шаардлага хангахгүй 94,471.2 мянган төгрөг, онгоцны тийз, ажлын тайлан, гэрээ дүгнэсэн актгүй 70,716.7 мянган, төгрөг, нийт 165,190.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна. | Сургалтад оролцсон нийт албан хаагчдаас үр дүнгийн тайлан болон бусад холбогдох анхан шатны баримтуудаа нөхөн бүрдүүлэн авсан болно. |
| 2.1 | Өмнөговь аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 1.5 сая төгрөг | Албан томилолт олгохдоо анхан шатны баримтын бүрдэл дутуу, хэдэн хувиар тооцох, явсан ирсэн огноогүй хөрөнгө зарцуулсан байна. | Албан томилолт зардлын хэмжээг Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаарт тушаалаар тооцон олгож 2024 оны байдлаар 20,786,000 төгрөгийн томилолт дээр хаалтын бичилтийг хийж ажиллав. |
| 2.1 | **ХХААХҮС 0.7 тэрбум төгрөг** | | |
| 2.1 | Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори-15.0 сая төгрөг | Анхан шатны цахим баримтын бүрдэл ханган ажиллаагүй 15.0 сая төгрөгний гүйлгээний баримтыг баримтжуулан баталгаажуулаагүй. | Анхан шатны цахим баримтын бүрдлийг ханган, анхан шатны ижь бүрэн баримтыг Finance.gov.mn -д байршуулан, нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, хууль тогтоомжийн хүрээнд ажиллаж байна. |
| 2.1 | Биокомбинат ТӨХХК-592.8 сая төгрөг | Тайлант онд худалдан авсан бараа ажил үйлчилгээний 592.8 сая төгрөгийн худалдан авалтын и-баримт татварын цахим системд бүртгэгдээгүй байна. | 2023 оны аудитын дүгнэлтээр тайланд онд худалдан авсан бараа ажил үйлчилгээний 592.8 сая төгрөгийн худалдан авалтын и баримт татварын цахим системд бүртгэгдээгүй гэсэн зөрчил илэрсэн. Энэ зөрчилд 68 гүйлгээний 52.4 сая төгрөгөөс 10 хувийг нь авч татварын байгууллагад шилжүүлсэн, 36 гүйлгээний 284.5 сая төгрөгийн и баримт цахим системд бүртгэгдсэн, 47 гүйлгээний 255.9 сая төгрөг нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд доголдол гарах, вакцин үйлдвэрлэлийн түүхий эд материал тасалдах, засвар үйлчилгээ хийх сэлбэг худалдан авах зэрэг яаралтай үйл ажиллагаанд зарцуулсан бөгөөд бараа материал нийлүүлэгч байгууллагуудтай холбогдон, нөхөн шивэлт хийлгэн дээрхи зөрчлийг арилгасан болно. |
| 2.1 | Сэлэнгэ аймгийн ХХААГ -15.0 сая төгрөг | Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр автомашины засвар үйлчилгээнд нийт 15.0 сая төгрөгийг зарцуулж, бүртгэл тайланд тусгасан. | Аудитын хэрэгжилтийг ханган бараа ажил үйлчилгээний төлбөрийн анхан шатны баримтыг нөхөн бүрдүүлсэн. |
| 2.1 | Төв аймгийн ХХААГ-43.8 сая төгрөг | 2023 онд зарцуулсан бичиг хэргийн материалын тайланд анхан шатны баримт дутуу, цахим баримтгүй ажил гүйлгээ гарган ажилласан. | Аудитаас өгсөн зөвлөмжийн хүрээнд бичиг хэргийн материалын анхан шатны баримтыг нөхөн бүрдүүлсэн. |
| 2.1 | Ховд аймгийн ХХААГ -3.0 сая төгрөг | Үзэсгэлэн худалдаатай холбоотой гарсан 3.0 төгрөгийн үнийн дүн бүхий зардлыг и-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримт бүрдүүлээгүй. | МУ-д шинжлэх ухааны Мал эмнэлэг, үржлийн албаа үүсэн хөгжсний 100 жилийн ойн хүрээнд шилмэл малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулахаар төлөвлөж үзэсгэлэн худалдааны зардалд зарцуулах 3.0 сая төгрөгийг Мал үржлийн албаны мэргэжилтэн С. Шүрхүүд шилжүүлсэн боловч үзэсгэлэн худалдааг зохион байгуулаагүй, анхан шатны баримт бүрдүүлэн ажилласаагүй нь аудитаар нотлогдож төлбөрийн акт тавигдсан байна. Уг төлбөрийн актыг хүлээн авсан С. Шүрхүү нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөөр ажлаас чөлөөлөгдөж өндөр настны тэтгэвэрт гарсан, тухайн үед төлбөрийн акт тавигдсан талаар дуудаж уулзан эргэж төлүүлэхээр мэдэгдсэн ба 2024 оны 7 дугаар сард төлөхөөр тохиролцсон, одоогийн байдлаар 2.2 сая төгрөгийг актын төлбөрийг барагдуулсан байна. |
| 2.1 | Ховд аймгийн ХХААГ -6.8 сая төгрөг | Томилолтын зардлын анхан шатны баримт ханган гаргалтгүй. | НҮБ-ын ХХАА-н газраас хаваржилт хүндэрсэн сумуудад хандив тусламжаар 16.3 сая төгрөгний санхүүжилт ирснээр Мал үржлийн албаны холбогдох мэргэжилтнүүд 17 суманд томилолтоор ажиллаж, мэдээ тайланг нэгтгэн, анхан шатны баримтын эх хувь НҮБ-ын ХХАА-н газарт хүргүүлсэн байна. Тухайн үед өөрийн санхүүгийн баримтанд хуулбарлан хавсаргаагүй байсан ба аудитын зөвлөмжийн дагуу хүргүүлсэн анхан шатны баримтыг хуулбарлан авч хэвлэн, анхан шатны баримтыг бүрдүүлэн аудитын явцад танилцуулан ажилласан. |

| Асуулга | Зөрчлийн агуулга | Зөрчил үүссэн тайлбар | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|
| 2.1 | **ХЗДХС-0.6 тэрбум төгрөг** | УБЕГ-ын харьяа байгууллагууд 485.6 сая төгрөгийн, ЦЕГ-ийн харьяа байгууллагууд 75.5 сая төгрөгийн, ШШЕГ-ийн харьяа байгууллагууд 14.3 сая төгрөгийн, ГИХГ-ийн харьяа байгууллагууд 2.8 сая төгрөгийн, ШШГЕГ-ийн харьяа байгууллагууд 0.1 сая төгрөгийн, бусад байгууллага 27.1 сая төгрөгийн, нийт 605.4 сая төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар хийсэн, шууд зардалд бүртгэсэн, буруулах бичилт хийсэн. | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 05 дугаар сарын 16-ний өдрийн 1/2 тоот Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээний тухай албан даалгавар гарч агентлаг байгууллагын дарга нарт үүрэг өгч, үр дүнг тооцож ажилласан. |
| 2.1 | УБЕГ 485.6 сая төгрөг | "Төрийн үнэт цаас хэвлэл" Төрийн өмч давамгайлсан ХХК 371.8 сая төгрөгийн бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ хийсэн, мөн 112.6 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зарцуулсан.<br>Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс 1.2 сая төгрөгийн шатахууныг анхан шатны баримтын бүрдэл дутуу зарцуулсан. | Төрийн үнэт цаас хэвлэл Төрийн өмч давамгайлсан ХХК нь 2023 оны 12-р сарын 3-нд "Смарт карт" ХХК-аас УБЕГ-т хүлээлгэн өгсөн гадаад пасспортын бэлдэц, хэвлэх машины хор, хорны сав, дагалдах хэрэгслийг 2024 оны 3-р сарын 27-нд утга оруулах хэсгийн ажилтнаас нэхэмжлэх гаргуулах, шаардлагыг хэрэгжүүлж ажиллаж байна. 2024 оны 4-р сараас эхлэн зөвхөн харилцах дансаар гүйлгээ хийж байгаа бөгөөд ажилчдын цалин, бараа материал худалдан авах, өр төлбөр төлөх зэрэг гүйлгээ кассаар /бэлэн мөнгөөр/ огт хийгдээгүй, кассын гүйлгээг дахин гаргаагүй ба зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж байна.<br>Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь шатахууныг анхан шатны баримтын иж бүрэн байдлыг хангаж, бараа материалд орлого аван, жолоочийн тооцооны хуудсыг үндэслэн анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллаж байна. |
| 2.1 | ЦЕГ 75.5 сая төгрөг | Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газар 25.9 сая төгрөг, Налайх дүүргийн цагдаагийн хэлтэс 1.6 сая төгрөг, Баянзүрх дүүргийн цагдаагийн газар 3.8 сая төгрөг, Булган аймгийн цагдаагийн газар 17.7 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэсэг 4.5 сая төгрөг, Хэнтий аймгийн цагдаагийн газар 5.0 сая төгрөг, Хөвсгөл аймгийн цагдаагийн газар 0.2 сая төгрөг, Санхүү ар талын алба 15.3 сая төгрөг | Хууль зүй, дотоод хэргийн сайдын Албан даалгавар гарч агентлаг байгууллагын дарга нарт үүрэг өгч, үр дүнг тооцож ажилласан. |
| 2.1 | Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газар 25.9 сая төгрөг | Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газар 25.9 сая төгрөгийн сургалтын зардлыг анхан шатны баримтын бүрдэл дутуу шууд зардалд бүртгэсэн гүйлгээ хийсэн байна. | Зохион байгуулсан сургалт, зөвлөгөөний анхан шатны баримтын бүрдэл, зарцуулалтын тайланг нэхэж хийж цаашид анхан шатны баримтын бүрдлийг бүрдүүлэн бараа материалын дансаар дамжуулан орлого, зарлагын гүйлгээг хийж Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлэн, цаашид "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 сургалт семинар хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон бусад зардлыг хэмнэх" гэсэн заалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. |
| 2.2 | Эрдэнэбүрэн сумын засаг даргын тамгын газар | Нэмэлт дансаар санхүүжилт хийгдсэн ажлуудын анхан шатны баримт, хүлээн авсан акт байхгүй, ямар ажил хийсэн нь тодорхойгүй зөрчил байна /Ойжуулалт арга хэмжээнд олгосон - 3.0 сая төгрөг | Төрийн сангийн мэргэжилтэн анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллаж байна. |

| Асуулга | Зөрчлийн агуулга | Зөрчил үүссэн тайлбар | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|
| 2.2 | Мест сумын орон нутгийн хөгжлийн сан | Худалдан авах ажиллагаа зохион байгуулж санхүүжилт олгохдоо анхан шатны баримт, гүйцэтгэлийн баримтуудад үндэслэн санхүүжилт олгоогүй, гэрээ дүгнээгүй, зарим төсөл арга хэмжээг акт үйлдэж ашиглалтад хүлээн аваагүй байхад санхүүжилт олгосон - 36.8 сая төгрөг | Ажил хүлээн авах комиссын акт болон холбогдох баримтыг үндэслэн гүйлгээ хийж байна. |
| 2.2 | Буянт сумын засаг даргын тамгын газар | Байгаль орчин хамгаалан нөхөн сэргээх зардлын анхан шатны баримт, ажлын тайлан дутуу хийсэн ажил тодорхой бус - 3.5 сая төгрөг | Байгууллагын данс бүртгэлд орлого авч, тайлан тооцоог бодсон. |
| 2.2 | Зэрэг сумын засаг даргын тамгын газар | Нутгийн зөвлөлийн үүлэлт хийх нөрвын дансанд шилжүүлсэн 4.2 сая төгрөгийн анхан | Данс бүртгэлд тусган орлого авч, зарцуулалтын тайлан гаргуулсан. |
| 2.2 | Дарви сумын засаг даргын тамгын газар | Бараа материал, хөрөнгийн тайлан гаргалт иж бүрэн биш, анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй, хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгө ангилан бүртгээгүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт хангаагүй | Бараа материалын тайланг журмын дагуу гаргаж, хөрөнгийн тооллогыг хийж нягтлан бодох бүртгэлд тусгасан. |
| 2.2 | Дэргэн сумын засаг даргын тамгын газар | Кассаар зарцуулсан мөнгө анхан шатны баримт дутуу, гарын үсгээр баталгаажуулаагүй, шатахууны тооцоо бодоогүй, жолоочийн замын хуудас засвар ихтэй, замын хуудсаар зарцуулсан шатахуун, бараа материалын тайлангаар зарлагдсан шатахуун зөрүүтэй - 14.7 сая төгрөг | Гарын үсгийн баталгаажуулалтыг хийж, жолоочийн тооцоо бодож шатахууны тайланг гаргасан. |
| 2.2 | Зэрэг сумын засаг даргын тамгын газар | Аймгийн Засаг даргаар хөтөлбөр, хандив дэмжлэг, хамтын сангаар Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлийн зөлгөлт зохион байгуулах удирдамж батлуулж төсөвриин хөлс, хөөл, бэлэг дурсгал бусад зардлыг төсөөс төлсөн, уг зардлуудын анхан шатны баримт хангалтгүй - 8.4 сая төгрөг | Төсөвриин хөлс төлсөн баримт, хоол, бэлэг дурсгалд төлсөн баримтыг бүрдүүлж, оролцсон хүмүүсийн нэрсийг хавсаргаж анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж дахин иймэ алдаа зөрчил гаргахгүй байхад анхаарч ажиллаж байна |
| 2.2 | Манхан сумын иргэдийн төлөөлөгчийн хурал | Иргэдийн төлөөлөгч нарын дансанд шилжүүлсэн үйл ажиллагааны зардал, улирал бүр олгосон шатахууны тооцооны хуудас, анхан шатны баримтгүй - 5.5 сая төгрөг | Замын хуудсыг хавсаргаж, шатахууны тооцоог бодсон. Анхан шатны баримтын бүрдүүлэн гүйлгээ хийж байна. |
| 2.2 | Манхан сумын засаг даргын тамгын газар | Засаг даргын нөөц хөрөнгөний зарцуулалт анхан шатны баримтгүй, нэг төрлийн ажил дээр олон удаа түшаал гаргаж хөрөнгө зарцуулсан, журам зөрчсөн зардал гаргасан - 18.7 сая төгрөг | Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын тайланг гаргуулж, данс бүртгэлд орлого авч зарцуулалтын тайланг гаргуулж зөрчлийг арилгасан. |
| 2.2 | Манхан сумын засаг даргын тамгын газар | 2023 оны 7, 8 сард олгосон Унааны зардал анхан шатны баримтгүй - 1.6 сая төгрөг | Замын хуудсыг хавсаргаж жолоочийн тооцоог тухай бүрд нь тооцож байна. |
| 2.2 | **Хэнтий аймаг 0.01 тэрбум төгрөг** | | |
| 2.2 | Орон нутгийн емчийн газар | Орон нутгийн емчийн газар төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1.6 сая төгрөгийн бараа материалыг анхан шатны баримтын бүрдэлгүй зарлагадсан. | Төрийн аудитын газраас 2024 оны 3 дугаар сард 19/А2370452/ХЭА-2024/31/ НА-СТА-ТШЗ дугаартай төлбөрийн акт тогтоогдсон. Төлбөрийн актын дагуу 2024 оны 6 дугаар сарын 24-ны өдөр төрийн сангийн нэр заагдаагүй бусад орлогын 100180000955 тоот дансанд 1.6 сая төгрөгийг тушаасан. |
| 2.2 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал анхан шатны баримтын бүрдэлгүй 1.0 сая төгрөгийн төсөв зарцуулалт хийсэн. | Төрийн аудитын газраас 2024 оны 3 дугаар сард төлбөрийн акт тавигдсан. Актын дагуу 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр төрийн сангийн нэр заагдаагүй бусад орлогын 100180000955 тоот дансанд 1.0 сая төгрөгийг тушаж актын биелэлтийг бивлүүлсэн. |
| 2.2 | Батноров сумын засаг даргын тамгын газар | Батноров сумын байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлаас шатахуунд 2.0 сая төгрөгийг тушаал шийдвэргүй, гүйцэтгэх ажлын удирдамж, төлөвлөгөө батлуулаагүй, гүйцэтгэсэн ажлын хэрэгжилтийн тайлан гаргаагүй зэрэг анхан шатны нотлох баримтын бүрдэлгүй зарцуулсан. | Батноров сумын байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас гарсан шатахууны гүйлгээг 2 хуваж шилжүүлсэн. Эхний гүйлгээг 2023.07.26-ны өдөр 982500 төгрөгийг шилжүүлэхдээ анхан шатны баримтад Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2023.07.05 өдрийн удирдамжийг хавсаргасан болно. Удирдамжийн хүрээнд хийсэн ажлын тайланг хавсаргаагүй гэдэг үндэслэлээр аудитын байгууллагаас зөвлөмж өгөгдсөн.<br>Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын 2023.07.05-ны өдрийн удирдамжийн дагуу гүйлгээ хийсэн. Гүйцэтгэсэн ажлын тайланг бүрдүүлэн санхүүгийн баримтад нөхөж хавсаргасан болно. Тус зөрчлийг ахин давтан гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллах болно. |
| 2-а | **Зөрчил 4-т заасан барва материалын нэр төрөл, зөрчлийн шалтгаан тус бүрийн дэлгэрэнгүй мэдээлэл, тайланг Төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр, мөн эдгээр барва материалыг хэрхсэн болон цаашид хэрхэх тухай дэлгэрэнгүй мэдээлэл** | | |
| 2-а | **Зөрчил -4: Бараа материалыг хэрэгцээнээс илүү болтгэсэн, хадгалалтын хугацаа хэтэрсэн, ашиглалтгүй, эргэлт удааширсан 73.8 тэрбум төгрөг /УУХҮС 65.9 тэрбум төгрөг, ЭХС 4.4 тэрбум төгрөг, БХБС 1.8 тэрбум төгрөг, ЭМС 1.3 тэрбум төгрөг, ХНХС 0.1 тэрбум төгрөг, ХХААХҮС 0.1 тэрбум төгрөг/** | | |
| 2-а | **УУХҮС-65.9 тэрбум төгрөг** | | |
| 2-а | Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК - 2,783.0 сая төгрөг | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захиалгаар Дархан төмөрлөгийн үйлдвэр ХХК нь 2017 оны 3 сард үйлдвэрлэсэн боловч зохих шаардлагыг хангаагүйгээс буцаагдсан 2,554 тонн хэмжээтэй 2,783.0 сая төгрөгийн өртгийн бөөрөнхий төмөр Ф-90 бэлдцийг 2018 оны 4 сарын 05-нд хүралдсан Техникийн комиссоос дотоод хэрэгцээнд болон бусад арга хэлбэрээр ашиглах судалгаа хийх шийдвэр гаргасныг хэрэгжүүлээгүй, хэвийн борлогдох бараа материалын дансанд ангилан бүртгэсээр байна. | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захиалгаар Дархан төмөрлөгийн үйлдвэр ХХК нь 2017 оны 3 сард 2.8 тэрбум төгрөгийн Ф-90 ган туйванг үйлдвэрлэсэн боловч зохих шаардлагыг хангаагүйгээс буцаагдсан. Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК-ны Гүйцэтгэх захирлын 2023 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн А/228 тоот тушаалаар ф-90 гөлгөр ган туйванг 1,692,400 төгрөгөөр худалдан борлуулах шийдвэр гарч борлуулах талаар судалгаа хийгдсэн. Ф-90 маркийн гөлгөр ган туйванг ганцхан Дарханы төмөрлөгийн үйлдвэрт давтах аргаар ган бөмбөлөг үйлдвэрлэдэг бөгөөд бусад аймагт үйлдвэрлэдэг буй ган бөмбөлөг нь цутгах аргаар үйлдвэрлэгдэж байна. Иймд ф-90 ган туйванг Монгол улсад худалдан борлуулах боломжгүй. 2023 оны 9 сард БНХАУ-ын нэр бүхий үйлдвэртэй холбогдон санал тавьсны үндсэн дээр манай үйлдвэрт өөрийн биеэр ирж үзсэн бөгөөд үнийн санал болон чанарын асуудлаас үүдэн худалдан авааг үйлдэж байна. 2024 оны хаяс жилийн тооллогоор ф-90-ийг дотооддоо ашиглах, зарж борлуулах талаар дахин судалж үзэх шийдвэр гаргахад Ган үйлдвэрлэл технологийн хэлтсээс бүтээгдэхүүний хими найрлагыг судалж үзэхэд үйлдвэрлэлд тодорхой хэмжээгээр хийгэдэ хаягдал төмрийн орлонд ашиглах боломжтой гэсэн хариу өгсөн. Иймд компанийн Техник технологийн зөвлөл болон Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн Гангийн үйлдвэрт түүхий эдээр дахин ашиглах шийдвэр гаргуулахаар төлөвлөн ажиллаж байна. |

| Асуулга | Зөрчлийн агуулга | Зөрчил үүссэн тайлбар | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|
| 2-а | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ - 63 4 тэрбум төгрөг | Агуулахад 63.4 тэрбум төгрөгийн 3-аас дээш жилийн насжилттай бараа материалын үлдэгдэл нь тухай үед ашуулгүйн нөөцийн зориулалтаар захиалж авсан бөгөөд техникийн шинэчлэлтэй холбоотой технологийн хоцрогдолд орсон, ашиглагдахгүй болсон бараа материал болно. | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн аудитын тайланд 3-аас дээш жилийн насжилттай 63,419.0 сая төгрөгийн бараа материал байна. Үүнд: 1. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т мөрдөгдөж буй "Ашуулгүйн нөөцийн журам"-д заасны дагуу гэнэтийн эвдрэл гэмтэл гарсан үед шуурхай засварлах, үйлдвэрлэлийн болон технологийн тасралтгүй үйл ажиллагаог хангах зорилгоор агуулахад нийт 42,056.0 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл байна. 2.Технологийн өрөтгөл шинэчлэлтэй холбоотой 3-аас дээш жилийн насжилттай 21,363.6 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэл байна. КПМЖ олон улсын аудитаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу бараа материалын үнэ цэний бууралтын хасагдуулгыг 21,363.6 сая төгрөгөөр тооцож байгуулсан. Мөн 2 дахь хэсэгт хамаарах бараа материалыг Төрийн өмчит болон уул уурхайн компаниудад санал болгож, худалдан борлуулах чиглэлээр Эрдэнэт ТӨҮГ-аас жил бүр зохион байгуулдаг "Уул уурхайн 7 хоног" нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулан ажилласан. Мөн Esale.erfenetmc.mn сайтаар дамжуулан зарим бараог худалдан борлуулах арга хэмжээ авч байна. |
| 2-а | **ЭХС-4.4 тэрбум төгрөг** | | |
| 2-а | Дулааны 4 дүгээр цахилгаан станц ТӨХК 3,171.8 сая төгрөг | Барааны үлдэгдэлдээ дүн шинжилгээ хийж, эргэлтийг сайжруулах талаар ажил зохион байгуулаагүй, техникийн шинэчлэлээр солигдсон бараа материалаа акталж хасаагүй, худалдан авалтыг төлөвлөхдөө агуулахын үлдэгдлийг харгалзаж үзээгүй зэрэг шалтгаалсан. | Бараа материалыг насжилтаар нь ангилан насжилтын нарийвчилсан судалгаа хийсэн. (5-7 жилийн насжилттай 332 нэрийн 1,530.0 сая төгрөг, 7-9 жилийн насжилттай 166 нэрийн 915.1 сая төгрөг, 9-с дээш жилийн насжилттай 303 нэрийн 1,287.4 сая төгрөгийн бараа материал байна.)<br>Нарийвчилсан судалгааны дараа холбогдох цех нэгжийн төлөвлөлтэй ажлын хэсэг байгуулан бараог нэг бүрчлэн үзэн ашиглах боломжтой эсэх судалгааг гаргасан. Үг ажлын хүрээнд 2024-2026 онд нийт 114 нэрийн 301.8 сая төгрөг, 337 нэрийн 2,040.7 сая төгрөгийн материалыг цаашид зарцуулах боломжтой гэсэн үр дүн гарсан. Цаашид ашиглах боломжтой бараа материалыг худалдан авалтын төлөвлөгөөнөөс хасах ажлыг удирдлагын түвшинд ярилцаж байна. 133 нэрийн 158.7 сая төгрөгийн материалыг шаардлага хангахгүй тул акталж, худалдан борлуулах санал гаргасан ба эдгээр бараатай холбоотой тоноглол иж бүрэн шинэчлэгдсэн, сайжруулсан учир сэлбэг материалыг цаашид ашиглахгүй гэдэг судалгаог харуусан цех нэгжээр гаргуулан ажиллаж байгаа ба цаашид Борлуулалт маркетингийн албатай хамтран үнийн судалгаа гаргаж өмч хамгаалах байгуулах зөвлөлд танилцуулан борлуулах ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна. 42 нэрийн 300.8 сая төгрөгийн материалыг шаардлага хангахгүй тул акталж, устгах үр дүн гарсан ба эдгээр бараог Хяналтын албанд нарийвчлан шалгуулж цаг хугацааны хувьд хуучирч муудсан, эсвэл эвдрэлтэй эсэх талаар судалгаа хийн холбогдох сэлбэг, материал ашиглалтаас хасах акт гаргах ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна. /Жагсаалтыг хавсаргав/ |
| 2-а | Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх ТӨХК-237.1 сая төгрөг | Эрчим хүчний сайдын 158 дугаартай журмын дагуу аюулгүйн нөөцийг бүрдүүлсэн байх шаардлагын дагуу үе шаттай нөхөн хангалтыг хийж байгаатай холбоотой өссөн. Компанийн зээмшилд 110/35/10 кВ-ын Бэрх дэд станц, 110/10 кВ-ын Чөлөөт бүсийн дэд станцууд ирсэнтэй холбоотой сүүлийн 2 жил аюулгүйн нөөцийг үе шаттай нэмэгдүүлсэн. | Багануур ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023.04.21-ний өдрийн А/185 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэг нь агуулахад байгаа бараа материалын насжилт, цаашид ашиглах боломжтой, ирэх оны бизнес төлөвлөгөөнд ашиглагдах боломжтой, худалдан борлуулах боломжтой, үхмэл хөрөнгө гэсэн ангиллаар тооллого судалгааг хийж компанийн Өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулан, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар 25 нэр төрлийн 21.2 сая төгрөгийн бараа материалыг худалдан борлуулахаар, 12 нэр төрлийн 5.0 сая төгрөгийн бараа материалыг акталж устгахаар шийдвэрлэсэн. Цаашид жил бүрийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнөөс агуулахын үлдэгдлийг хасаж төлөвлөх ажил хийгдэж байна. 2023 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнөөс 90.0 сая төгрөг, 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнөөс 43 нэр төрлийн 60.6 сая төгрөгийн агуулахад байгаа бараа материалыг хасаж, шаардлагагүй бараа материал авах, агуулахын үлдэгдэл өсөх, үргүй зардал гаргахгүй байх тал дээр хяналт тавин ажиллаж байна./Жагсаалтыг хавсаргав/ |
| 2-а | Улаанбаатарын цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-688.7 сая төгрөг | УБЦТС ТӨХК-ийн нийт активын 80 орчим хувийг 511.3 тэрбум төгрөгийн анхны өртөгтэй 163.2 тэрбум төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 348.0 тэрбум төгрөгийн дансны үнэтэй үндсэн хөрөнгө эзэлдэг бөгөөд эдгээр хөрөнгийн насжилт нь 50 хүртэлх жилийн насжилттай ч байдаг. Үүнээс шалтгаалан тэдгээр хөрөнгийн их, урсгал засварт шаардагдах сэлбэг хэрэгслийг мөн нөөцлөх шаардлагатай болдог. Энэ нь аюулгүй нөөцөөс өөр ангилал бөгөөд насжилт өндөртэй хуучны тоноглол, хөрөнгөд шаардлагатайн улмаас түс сэлбэг хэрэгслийн эргэц удааширдаг. Өөрөөр хэлбэл эдгээр хуучны цахилгаан тоноглолд шаардлагатай сэлбэг материал нь олдоц муу, зарим нь технологийн дэвшлийн улмаас үйлдвэрлэгдэхээ больсон сэлбэгүүд ч байдаг. Эдгээр шалтгааны улмаас, хуучны сэлбэгүүд эргэц удаан, ашиглагдах нь тодорхой бус байдаг. | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2024.05.30-ны өдрийн Б/196 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан 136 нэр төрлийн 1,165.6 сая төгрөгийн эргэлт удаан, насжилт өндөртэй бараа материалыг цаашид ашиглах болон худалдан борлуулах саналыг боловсруулан компанийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2024.08.27-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, нийт 1,005.8 сая төгрөгийн бараа материалыг 2025 оны төлөвлөгөөнд тусгаж эргэлтэд оруулах, ашиглах боломжгүй 159.8 сая төгрөгийн материалыг актлах, худалдан борлуулах саналыг захирлын зөвлөлийн хуралд танилцуулахаар шийдвэрлэсэн байна. /Жагсаалтыг хавсаргав/ |

| Асуулга | Зөрчлийн агуулга | Зөрчил үүссэн тайлбар | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|
| 2-а | Дулааны 3 дугаар цахилгаан станц ТӨХК-366.6 сая төгрөг | Станцын хэвийн, найдвартай үйл ажиллагаог хангах үүднээс зарим тоноглолын сэлбэг, материалууд агуулахад тодорхой хэмжээний нөөцтэй байх зайлшгүй шаардлагатай байдаг. Зарим төрлийн сэлбэгүүд нь олдоц ховор, гаднын улсад захиалга өгч үйлдвэрлүүлдэг цаг хугацаа их ордог зэрэг нь үйлдвэрлэлийн ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй тул агуулахад нөөц үүсэхэд нөлөөлсөн. 2022 онд Ковид-19 халдварт өвчний улмаас хөөр улсын хил удаан хугацаагаар хаалттай байсан бөгөөд энэ үеэр станц нь сэлбэг хэрэгслийн хомсдолд орж байсан тул дээрх нөхцөл байдал дахин давтагдахаас сэргийлж шаардлагатай материалын нөөцийг хангасантай холбоотой. | Станцын хэвийн, найдвартай үйл ажиллагаог хангах үүднээс зарим тоноглолын сэлбэг, материалууд агуулахад тодорхой хэмжээний нөөцтэй байх зайлшгүй шаардлагатай байдаг. Зарим төрлийн сэлбэгүүд нь олдоц ховор, гаднын улсад захиалга өгч үйлдвэрлүүлдэг цаг хугацаа их ордог зэрэг нь үйлдвэрлэлийн ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй тул агуулахад нөөц байх шаардлагатай байдаг. Мөн 2022 онд Ковид-19 халдварт өвчний улмаас хөөр улсын хил удаан хугацаагаар хаалттай байсан бөгөөд энэ үеэр станц нь сэлбэг хэрэгслийн хомсдолд орж байсан тул дээрх нөхцөл байдал дахин давтагдахаас сэргийлж шаардлагатай материалын нөөцийг хангаж ажилласан. 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 56 нэр төрлийн 366.5 сая төгрөгийн бараа материал, сэлбэг хэрэгсэл эхний үлдэгдэлтэй байхад нэмж бэлтгэн, тайлант хугацаанд зарцуулаагүй байна гэж албан шаардлага өгсөн. Эдгээр 56 нэр төрлийн сэлбэг материалын үлдэгдэл нь 2023 оны жилийн эцсийн байдлаар 581.2 сая төгрөг байсан бөгөөд тухайн онд орлого авсан барааны дүн нь 366.5 сая төгрөг юм. 2024 оны 3-р улирлын байдлаар орлогод аваад зарцуулагдаагүй 366.5 сая төгрөгийн бараанууд үйлдвэрлэлд зарцуулагдсан бөгөөд 258.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. 2024 тайлант жил дуусах хүртэл дахин зарцуулагдах төлөвтэй байна. 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа агуулахад үлдэгдэлтэй бараа хасаж төлөвлөх тал дээр анхааран ажиллаж байна. /Жагсаалтыг хавсаргав/ |
| 2-а | **БХБС-1.8 тэрбум төгрөг** | | |
| 2-а | Цемент шохой ТӨХК-1.811 сая төгрөг | Цемент Шохой ТӨХК бараа материалын нөөц байхад 757.4 сая төгрөгийн бараа материал шинээр худалдан авсан, агуулахад олон жил 1,054.4 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна. | Цемент шохой ТӨХК-н гүйцэтгэх захирлын "Бараа материалын өнөөгийн үнэ цэнээр бүртгэх тухай" 2024.08.29-ны №А/212 тоот тушаал, "Үнэ судлах комисс томилох тухай" 2024.08.15-ны №А/204 тоот тушаалаар үүрэг чиглэл өгөгдөж, үнэ судлах комиссын гишүүдээр зах зээлийн үнийн судалгаог хийлгэн 2022-2023 онуудад зарлага хийгдээгүй 2,991.2 сая төгрөгийн агуулахын үлдэгдэлтэй бараа материалд үнэ цэний бууралт тооцохоор ажиллаж байна.<br>2. 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө анхны байдлаар 71,268.7 сая төгрөгөөр батлагдсанаас, үйлдвэрлэлийн агуулахын үлдэгдэл болон зарим шаардлагагүй худалдан авалтуудыг хасаж /9,524.5 сая төгрөг/ нийт 61,744.2 сая төгрөгөөр худалдан авалтын төлөвлөгөөг Эрдэнэс Монгол ХХК-д танилцуулж баталгаажуулсан. /Жагсаалтыг хавсаргав/ |
| 2-а | **ЭМС-1.3 тэрбум төгрөг** | | |
| 2-а | Өргөө амаржих газар 155.6 сая төгрөг | Хадгалалтын хугацаа дууссан агуулахад байгаа 35 нэр төрлийн 8.6 сая төгрөгийн эм, тусламжаар ирсэн 16 нэрийн 145.3 сая төгрөгийн ковид-19 цар тахлын эм, тариа байна. | Өргөө амаржих газар нь ковид-19 цар тахлын үед эмийн нөөц бүрдүүлэх зорилгоор ЭМЯ-наас үнэ төлбөргүй ирсэн эм, оношлуур, тариа 17 төрлийн 145342.1 мянган төгрөг, өөрийн санхүүжилтээр худалдан авсан эмийн агуулахад бүртгэлтэй 35 нэр төрлийн 4237.0 мянган төгрөгийн эм, тарилгын уусмал, эмнэлгийн хэрэгсэл, тасаг нэгжүүдийн ажлын шүүгээнд зайлшгүй байх 20 нэр төрлийн 4412.6 мянган төгрөгийн эм тариа хугацаа дууссан байсан бөгөөд 2023.12.27-ний А78 тоот тушаалаар 153,991,921.67 төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг 2023 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн Эмийн эмчилгээний зохицуулах хорооны шийдвэрийг үндэслэн Элемент медикал ХХК-тай гэрээтэй учир устгал хийж акталж устгасан. /54 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл акталсан тухай жагсаалтыг хавсаргав/ |
| 2-а | Улсын хөөрдугаар төв эмнэлэг 734.7 сая төгрөг | Хугацаа дууссан 26 нэр төрлийн 685.4 сая төгрөгийн эм тариа, 5 нэр төрлийн мансуурах эмийн тунгийн үлдэгдэл, шил 87.9 мянган төгрөг байна. | Улсын Хөөрдугаар төв эмнэлэг нь заавал байх шаардлагатай мансууруулах, сэтгэц нөлөөт эм, ЭМЯ-аас ковид-19 цар тахлын үед үнэ төлбөргүй ирүүлсэн хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгслийг ерөнхий захирлын 2024.04.26 өдрийн А/88 дугаар тушаалын дагуу ажлын хэсэг байгуулж, дууссан цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй эм тариа, эмнэлгийн хэрэгслийг устгаж актлалсан. /28 нэр төрлийн 26811 ширхэг хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг хавсаргав/ |
| 2-а | Хүрэз амаржих газар 15.9 сая төгрөг | Хугацаа дууссан 15 нэр төрлийн 24.5 сая төгрөгийн эм байна. | Хүрэз амаржих газар нь ЭМЯ-аас үнэ төлбөргүй тусламжаар ирүүлсэн хугацаа дууссан 15 нэр төрлийн 24,594,985 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг байгууллагын эмийн эмчилгээний хороо, удирдлагын багийн хурлаар оруулан хэлэлцүүлж протокол хөтөлж амаржих газрын даргын А/19 тоот тушаалаар акталж устгасан. /15 нэр төрлийн 20078 ширхэг хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг хавсаргав/ |
| 2-а | Баянгол дүүргийн ЭМТ 133.0 сая төгрөг | Ковидын тест 2060 ширхэг, окситоцин 350 ширхэг, арбидол 9491 ширхэг, тоцилизумаб 65 ширхэг хугацаа | Эрүүл мэндийн яамнаас ковид-19 цар тахлын үед үнэ төлбөргүй ирүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийг Баянгол дүүргийн эрүүл мэндийн эмийн хороогоор хэлэлцэн байгууллагын даргын 2024 оны 09 дүгээр сарын 10-ний өдрийн А/113 тушаалаар комисс томилон акталж устгасан. |
| 2-а | Төв аймгийн нэгдсэн эмнэлэг 282.6 сая төгрөг | Тоцилизумаб 160 ширхэг, ремдесивир 1054 ширхэг, дексаметазон 22500 ширхэг, арбидол 24000 ширхэг, тамифлю 120 ширхэг, хоросол 6400 ширхэг хадгалах хугацаа дууссан эмтэй | 2023 оны жилийн эцсээр Төв аймгийн нэгдсэн эмнэлэгт ковид-19 цар тахлын үед нийлүүлэгдсэн эм эмнэлгийн хэрэгслээс ашиглагдахгүй үлдэж хугацаа нь дууссан эм, тариа оношлуурыг 2024 онд Элемент устгал ХХК-тай гэрээ байгуулан хугацаа дууссан материалыг актлалж гэрээний дагуу устгасан. /6 төрлийн 54234 ширхэг эмийг устгаж, актлсан жагсаалтыг хавсаргав/ |
| 2-а | Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ЭМТ 5.2 сая төгрөг | Ковид-19 цар тахлын 5.2 сая төгрөгийн оношлуур хугацаа дууссан | Эрүүл мэндийн яамнаас ковид-9 цар тахлын үед үнэ төлбөргүй ирүүлсэн эм, эмнэлэгийн хэрэгслийг хугацаа дууссан оношлуурыг Өмч хамгаалах комиссоор устгасан. |
| 2-а | Орхон сумын ЭМТ 2.6 сая төгрөг | Хугацаа дууссан 2.6 сая төгрөгийн эм, оношлуур хадгалагдаж байна. | Сэлэнгэ аймгийн Орхон сумын эрүүл мэндийн төвийн 2.6 сая төгрөгийн Эрүүл мэндийн яамнаас ковид-19 цар тахлын үед үнэ төлбөргүй ирүүлсэн хугацаа дууссан эм, оношлуурыг Өмч хамгаалах комиссоор устгасан |
| 2-а | **ХНХС 0.1 тэрбум төгрөг** | | |

| Асуулга | Зөрчлийн агуулга | Зөрчил үүссэн тайлбар | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|
| 2-а | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 89.3 сая төгрөг | Бараа материалын дэлгэрэнгүй тайланд 28812 ширхэг 81,848.3 мянган төгрөгийн 2021 оны эрхийн бичиг, хаяг, засварын материал, оролцоо теселтэй холбоотой бараа материал зэрэг хэрэгцээ шаардлагагүй бараа бүтээгдэхүүнийг их хэмжээгээр нөөцөлж, бараа материалын тайланд бүртгэлийн хөдөлгөөн хийгдээгүй байна. | Нийгмийн халамж болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаатай холбоотой тус байгууллагын агуулахад байрлах цаасан суурьтай ном, хэвлэмэл маягтыг шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүний ХХҮЕГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/35 дугаар тушаалаар байгуулан хэрэгжилтийн хүрээнд бүртгэл, тулгалтыг хийж байгууллагын ємч хамгаалах байгныг зөвлөлөөр хэлэлцүүлж 585600 ширхэг 9 нэр төрлийн баримтыг актлаж устгах, 194173 ширхэг ашиглаж болох материалуудыг аймаг, нийслэл дүүргийн ХХҮГ, хэлтсүүдэд тараах саналыг гаргасан. Өмч хамгаалах комиссын гишүүдийн санал, дүгнэлт, ажлын хэсгийн гишүүдийн саналын хамт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдөр ХХҮЕГазрын даргад саналыг холбогдох материалуудын хамт хүргүүлж 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/311 тушаалаар бараа материалыг актлах, тараах материалыг шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. /5 нэр төрлийн 442432 ширхэг бараа материалын жагсаалтыг хавсаргав/ |
| 2-а | ХГБХХЕГ болон харьяа байгууллага- 19.6 сая төгрөг | | |
| 2-а | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалллын ерөнхий газар 8.5 сая төгрөг | Бараа материалын дансанд тайлант оны эцэст нөөцлөх шаардлагагүй 8,466.8 мянган төгрөгийн түлш, шатахууны зарцуулагдаагүй үлдэгдэл байна. | Агентлагийн даргын 2024 оны А/12, А/16, А/27, А/34, А/63, А/76, А/69, А/79, А/80 дугаар тушаалаар түлш шатахууны талоныг тухай бүрд нь зарцуулан үлдэгдэлгүй болсон. Цаашид үлдэгдэлгүй тухай бүр зарцуулалтаа хийж ажиллаж байна. |
| 2-а | Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний тев 7.8 сая төгрөг | Бараа материалын тайланд биетээр оршин байхгүй 7,850.0 мянган төгрөгийн плакат, тараах материал бүртгэлтэй байна. | Бараа материал зарлагдсан. Оны эцэст төлберийг шилжүүлсэн бөгөөд тараах материалыг хүлээж авааагүй байсан. |
| 2-а | Хүүхэд хамгаалллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр 3.3 сая төгрөг | Бараа материалын тайланд 1024 ширхэг нөөцлөх шаардлагагүй 3,314.2 мянган төгрөгийн аж ахуй, хүнсний материалыг үлдэгдлээр тайлагнаж, орлого, зарлагын хөдөлгөөн хийгдээгүй байна. | Бараа материалын үлдэгдлийг оны сүүлийн өдрүүд байсан тул түр хамгаалах байранд байрлаж байгаа хүүхдүүдэд тодорхой хэмжээний хоол хүнсний материал хэрэгцээний дагуу урьдчилан худалдан авсан байсан. Бусад тохиолдолд урьдчилан нөөцлөхгүйгээр орлого зарлагын гүйлгээ тухай бүр шилжүүлж байгаа. |
| 2-а | **ХХААХҮС-0.1 тэрбум төгрөг** | | |
| 2-а | Мал эмнэлгийн ерөнхий газар-106.7 сая төгрөг | Бараа материалын дансанд мялзан өвчний 433,800 тун, хонины цэцэг өвчний тун 65,600 тун нийт 106.1 сая төгрөгийн 2022 оноос шилжин ирсэн хугацаа дууссан вакцины үлдэгдлийг устгаж, данс бүртгэлээс хасаагүй байна. | Мал, амьтны халдвэрт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрадзлийг бууруулах зорилгоор 2017-2021 онуудын вакцины эргэлтээс үүссэн мялзан өвчний 433,800 тун, хонины цэцэг өвчний 65,600 тун нийт 106.1 сая төгрөгийн үнэ бүхий вакцины үлдэгдэл 2022 оноос шилжин ирсэн, хугацаа дууссан вакцины үлдэгдлийг устгах ажлын хэсгийг шинэчлэн байгуулж устгалд оруулахаар ажиллаж байна. |
| **3** | **Асуулга 3 - Зөрчил 6,6-д заасан дүн бүхий баталсан төсвийн хэрэхэн хэтрүүлсэн, зориулалт бусаар юунд, хэрхэн үр ашиггүй зарцуулсан тухай дэлгэрэнгүй мэдээлэл, тайланг Төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр, мөн хохирлыг хэрхэн барагдуулах тухай мэдээлэл** | | |
| **3.1** | **Зөрчил-6:Баталсан төсвийн хэтрүүлсэн, зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан 13.9 тэрбум төгрөг /БШУС 4.9 тэрбум төгрөг, МУЕП 3.0 тэрбум төгрөг, ХНХС 2.3 тэрбум төгрөг, УУХҮС 1.1 тэрбум төгрөг, Соёлын сайд 0.9 тэрбум төгрөг, Сангийн сайд 0.5 тэрбум төгрөг, ЭМС 0.5 тэрбум төгрөг, ЭХС 0.4 тэрбум төгрөг, ШСХ 0.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.2 тэрбум төгрөг/** | | |
| 3.1 | **БШУС-4.9 тэрбум төгрөг** | | |
| 3.1 | Боловсролын ерөнхий газар - 2,323.9 сая төгрөг | Батлагдсан төсвийг хэтрүүлсэн, зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан, зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан, хоорондын тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн, хяналтгүй зарцуулсан 2,323.9 сая төгрөг /ЕБС-ийн118 зөрчил 1,421.3 сая төгрөг, СӨББ-ын 99 зөрчил 611.8 сая төгрөг, МББ-ын 8 зөрчил 96.8 сая төгрөг, НТББ-ын 4 зөрчил 3.8 сая төгрөг, БЕГ-ын аппаратын 1 зөрчил 190.2 сая төгрөг/; | Төвлөрүүлэн захирагчийн нэгдсэн санхүүгийн тайланд тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хүрээнд урьдчилж төлегдсөн зарим гэрээний төлбөр болон сургууль, цэцэрлэгийн гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцооны хүрээнд сургалтын үйл ажиллагаанд зарцуулагдаж буй хөрөнгийг бараа материалын бүртгэлд тусгахгүйгээр зардалд бүртгэсэн зэрэг сургалтын байгууллагын онцлог, хичээлийн жил, төсвийн жилийн зөрүүтэй байдлыг харгалзаагүй нийт зөрчилд тусгасан зэрэг асуудлууд багтсан ба Аудитын тайлангийн дагуу Боловсролын ерөнхий газраас 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 01/2029 тоот албан бичгийг харьяа байгууллагуудад хүргүүлж ажилласан. 2024 оны 10 дугаар сард аймаг дүүргийн мэргэжилтнүүдэд сургалт хийхээр төлөвлөн ажиллаж байна. Аудитын зөвлөмжийн биелэлт 70%-тай байна. |
| 3.1 | МУИС - 264.0 сая төгрөг | Дижитал Воркс ХХК-тай 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдөр "Төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн программ хангамж нийлүүлэх" МУИС/202004042 тоот гэрээ байгуулсан. 2023 оныг дуустал 4 удаагийн нэмэлт гэрээгээр дээрх программ хангамж нийлүүлэх гэрээний хугацааг сунгаж программыг 4 нэгж дээр туршилт хийж санхүүгийн программын модуль бүр дээр ажиллан санхүүгийн бүх тайланг гаргаж 2022 оны 12 дугаар сард гэрээний дүнгийн 95 хувийг буюу 264.0 сая төгрөгийг шилжүүлсэн байсан. | МУИС-ийн 8 бүрэлдэхүүн сургууль, хөдөө орон нутгийн 3 салбар сургууль. 1 ерөнхий боловсролын сургууль, 3 хүрээлэн, оюутны байр, захиргаа аж ахуй нийт 27 салбар нэгжтэй, 844 таран багш ажилтантай, 27.8 мянга гаруй оюутан суралцагчтай үйл ажиллагаа явуулдаг. Санхүү, бүртгэл, удирдлагын нэгдсэн программ хангамжийг 2021 оноос хойш хэсэгчлэн хөгжүүлж 2024 оны эхний хагас жилд бүрэн хэмжээгээр ашиглалтад оруулан хүлээн авсан ба цаашид энэхүү программ хангамжийг бүрэн ашиглах, оюутны сургалтын төлберийг шууд hemis программаас татаж орлогын тооцоог хийх, санхүүгийн тайланг стандартын хүрээнд бүрэн гаргах боломж бүрдэж байна. Дижитал Воркс ХХК-тай 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдөр "Төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн программ хангамж нийлүүлэх" МУИС/202004042 тоот гэрээ байгуулж 2023 онд 4 удаагийн нэмэлт гэрээгээр дээрх программ хангамж нийлүүлэх гэрээний хугацааг сунгасаар 2022 оны 12 дугаар сард гэрээний дүнгийн 95 хувь 264.0 сая төгрөг шилжүүлж программ хангамжийг бүрэн хүлээн авч 2024 оны эхний хагас жилд хэй хамтран үнийн с |
| 3.1 | Завхан БШУГ - 95.0 сая төгрөг | 2023 оны жилийн эцсийн санхүүгийн аудитаар нийт 95.0 сая төгрөгийг нярав болон бусад албан хаагчдын хувийн дансаар гүйлгээ гаргаж, зарцуулсан тул сөрөг аудитын дүгнэлт авсан байна. | ТЕЗ-н зүгээс хариуцлага тооцох албан тоотыг хүргүүлж, холбогдох хуулийн хүрээнд хариуцлага тооцуулахаар ажиллаж байна. Томилсон эрх бүхий албан тушаалтан буюу БЕГ-н даргын 2024 оны 01/2029 тоот албан тоотоор төсвийн шууд захирагчид сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг ирүүлэх албан тоотыг хүргүүлсэн. Аудитаас тогтоосон 21.7 сая төгрөгийн актын төлберийг бүрэн төлж барагдуулсан байна. |

| Асуулга | Зөрчлийн агуулга | Зөрчил үүссэн тайлбар | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|
| 3.1 | Боловсролын зээлийн сан - 880.2 сая төгрөг | Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлгээр гадаад улсад суралцаж байгаа 176 суралцагч дотоодын их сургуулийн бэлтгэл хөтөлбөр болон гадаадын их сургуулийн суурь хөтөлберт хоёуланд нь хамрагдаж тэтгэлэгт хамрагдсан гэдгийг зөрчилд тооцсон байна. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлгээр гадаад улсад суралцаж байгаа 176 суралцагч дотоодын их сургуулийн бэлтгэл хөтөлбөр болон гадаадын их сургуулийн суурь хөтөлберт давхар хамрагдаж, дахин сургалтын тэтгэлэгт хамрагдсан зөрчил тооцсон. Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан 102 дугаар тогтоолоор журмын өөрчлөлт оруулан батлуулсан. Журмын 3.31-д "3.2.1-д заасан суралцагчийг /3.2.1.Монгол Улсын нийт сум, хороо бүрээс шалгарсан суралцагч/ Засгийн газар хоорондын болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, санаас хийсэн хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хүрээнд гадаадын сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцуулна. Суралцагч бэлтгэл хөтөлбөрт суралцаж, болно." заалтыг тусгаж оруулсан. |
| 3.1 | Шинжлэх ухаан технологийн сан - 74.4 сая төгрөг | 2023 оны санхүүгийн тайланд дотоод, гадаад албан томилолт болон гэрээний төлбөр 74,365.6 мянган төгрөгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн. | Аудитын явцад шууд зардлаар бүртгэсэн дотоод, гадаад томилолт болон гэрээний урьдчилгаа төлберийг тооцооны дансаар дамжуулан урьдчилгаа бүртгэж, бүртгэлийг зөв болгож тайлагнасан. |
| 3.1 | МУБИС - 62.1 сая төгрөг | Төсвийн хөрөнгөөр 62.1 сая төгрөгийн хоол хүнсний бүтээгдэхүүн худалдан авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил гарсан. | Тус сургууль нь 7 бүрэлдэхүүн сургууль, хөдөө орон нутгийн 2 салбар сургууль, 1 ерөнхий боловсролын сургууль, оюутны байр, захиргаа аж ахуй нийт 13 салбар нэгжтэй, 1000 гаран багш ажилтантай, 12.0 мянга гаруй оюутан суралцагчтай үйл ажиллагаа явуулдаг. Багш, оюутны олон улсын эрдэм шинжилгээний хурал семинар, багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт, хамтын ажиллагааны хүрээнд байгууллагуудтай хамтарсан сургалт судалгаа бусад үйл ажиллагааныд байнга зохион байгуулагддаг. Сургалтад зарцуулагдсан хоол цайны зардал байсан цаашид дахин зөрчил гаргахгүй байхаар анхааран ажилляж байна. |
| 3.1 | **бусад харьяа байгууллага - 181.0 сая төгрөг** | | |
| 3.1 | Завхан аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар - 17.7 сая төгрөг | Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан Чадварлаг багш хөтөлберийн хөрөнгийг зориулалт бус зарцуулж, албан хаагчдыг БНХАУ-д аялуулсан 8.0 сая төгрөгийн акт, Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан Чадварлаг багш хөтөлберийн хөрөнгийг зориулалт бус байгууллагын урсгал үйл ажиллагаанд зарцуулсан 4.2 сая төгрөг албан шаардлага, боловсролын байгууллагуудын удирдлагуудыг чадавхжуулах сургалтын хүрээнд төсвөөс хоолны мөнгө төлсөн 5.5 сая төгрөг. | Аудитаар илрүүлсэн зөрчлийг арилгахаар ажиллаж байна. Завхан аймгийн Төрийн аудитын газарт 8.0 сая төгрөгийн актын төлберийг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл хойшлуулах хүсэлт хүргүүлсэн байна. |
| 3.1 | Боловсролын үнэлгээний төв -8.3 сая төгрөг | Тайлант онд 8,327.3 мянган төгрөгийн бичиг хэрэг, хоол хүнсний зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулсан. | Бичиг хэрэг, хоол хүнсний зардлыг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан байсан тул зөрчлийг давтан гаргахгүй байх талаар аудитаас өгсөн зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэн ажиллаж байна. |
| 3.1 | Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль - 14.7 сая төгрөг | Бусад төлбөр, хураамж татварын зардал дансанд 14,700.0 мянган төгрөгийн харуул хамгаалалтын зардлыг бүртгэсэн байна. | Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. |
| 3.1 | Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль - 32.7 сая төгрөг | Удирдах зөвлөлийн шийдвэр, хөрөнгө зарцуулах төсөв батлагдаагүй байхад VIP шүдний эмнэлэг байгуулж 32.7 сая төгрөгийн зардал гарган нягтлан бодох бүртгэлд тусгасан байна. | Төрийн емчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 83 тоот тогтоолоор батлуулсан төлөвлөгөөний дагуу их засвар, хөрөнгө оруулалтын ажлыг хэрэгжүүлэхдээ ТБОНӨХБАУХАТ хуулийг мөрдөн ажиллаж байна. |
| 3.1 | Шинжлэх ухаан, технологийн сан - 38.1 сая төгрөг | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын төсөөс эдийн засгийн ангилал зөрчил төсөлд тусаагүй Олон улсын хурал зөвлөгөөнд оролцох зориулалт бүхий 38,146.3 мянган төгрөгийн гадаад томилолтын зардал гаргасан. | БШУС-ын 2023 оны 10 сарын 31-ний А/463 тоот тушаал, Шинжлэх ухаан, технологийн сангийн захирлын 2023 оны 11 сарын 03-ны А/16 тоот тушаалаар БНХАУ-ын "Бүс ба зам", "Шинжлэх ухаан, технологийн солилцоо" хурал сургалтад хамрагдсан. Одоогоор эдийн засгийн ангилал зөрчин төсвийн төсөлд тусаагүй, зардал гаргахгүй ажиллаж байна. |
| 3.1 | МАА-н эрдэм шинжилгээний хүрээлэн - 23.1 сая төгрөг | 2023 оны санхүүгийн тайланд бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлын ангилаас гэрээний төлбөр 23,067.9 мянган төгрөгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна. | НББ-ийг БШУЯ-ны харьяа байгууллагуудад мөрдөх бодлогын баримт бичгийн дагуу хөтлөн, харилцагч байгууллагуудад төлж буй төлберийг тооцоо үүсгэн, тооцооны дансаар дамжуулан төлж, 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг бэлтгэн гаргалаа. |
| 3.1 | Цэмийн энергийн комиссын Ажлын алба - 25.1 сая төгрөг | Гадаад томилолтын 18,497.3 мянган төгрөгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн, гадаад томилолтын зарцуулагүй үлдэгдэл 6,645.5 мянган төгрөгийн зардал буруулах бичилт хийсэн байна. | НББ-ийг БШУЯ-ны харьяа байгууллагуудад мөрдөх бодлогын баримт бичгийн дагуу хөтлөн, харилцагч байгууллагуудад төлж буй төлберийг тооцоо үүсгэн, тооцооны дансаар дамжуулан төлж, 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг бэлтгэн гаргалаа. |
| 3.1 | Математик тоон технологийн хүрээлэн - 6.4 сая төгрөг | Хангамж бараа материалын данснаас 4.8 сая төгрөг, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх данснаас 0.3 сая төгрөгийг, ном бүтээл хэвлүүлэх зардал 1.3 сая төгрөгийг тус тус тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн. | 2024 оны эхний хагас жилийн байдлаар бараа материалын зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, ном бүтээл хэвлүүлэх зардлаас гарсан гүйлгээг тооцооны дансаар дамжуулан зардлаар бүртгэн ажиллаж байна. |
| 3.1 | **МУЕП-3.0 тэрбум төгрөг** | Улсын ерөнхий прокурорын 2023 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж 2024 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн 854/А0121241 дугаартай "Урсгал зардлын төсөөс хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл, арга хэмжээ санхүүжүүлсэн, баталсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, Ахмадын сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд ашигласан зөрчлийг арилгах" зөвлөмжийг өгсөн. | Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын даргаар тайлант онд хийх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулан ажиллаж байгаа бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Прокурорын байгууллагын Ахмадын сангаас хөрөнгө оруулалтын шинж чанартай аливаа ажил гүйлгээг санхүүжүүлэхгүй, төсвийг зориулалтын дагуу зарцуулж, түүнд хяналт тавин ажиллаж байна. Цаашид ахмадын сангаас хөрөнгө оруулалтын шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэхгүй бөгөөд хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахад бүртгэлээр тавих хяналтын сайжруулан ажиллах болно. |
| 3.1 | **ХНХС-2.3 тэрбум төгрөг** | | |
| 3.1 | ХГБХХЕГ , НДЕГ болон харьяа байгууллага- 253 сая төгрөг | | |
| 3.1 | Өмнөговь аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 6.5 сая төгрөг | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн зэ зүйлсийн зардлаас малгай, цамц 2,919,400 төгрөг, гэрийн бүрээс 2,100,000 төгрөг, гэрийн чимэл төсөл 1,449,900 төгрөг, нийт 6,469,300 төгрөг зарцуулж төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. | Төсвийн тухай хуулийн 42-р зүйлд заасан дагуу нэмэлт төсвийг өөрийн нэмэлт дансаар дамжуулан хүлээн, авч зохих зардлын ангилалын дагуу зарцуулан ажиллаж байна. |
| 3.1 | Багаханғай дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс 1.5 сая төгрөг | Сургалтын арга хэмжээ зохион байгуулахад чихэр, цай, кофены үр ашиггүй зардал гаргасан | Сургалтын зардалд үр ашиггүй зардал гаргахгүйд анхааран ажиллаж байна. |

| Асуулга | Зөрчлийн агуулга | Зөрчил үүссэн тайлбар | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|
| 3.1 | Говьсүмбэр аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар 8.3 сая төгрөг | Сургалт, зөвлөгөөн, бусад үйл ажиллагаа зохион байгуулахдаа хоол, бэлэг дурсгалын зүйлд төсөв зарцуулж төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан. | Төрийн хэмнэлтийн хуулийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах". 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалт нь хүчингүй болсон./Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./Иймд чиг үүргийн байгууллагын хувьд сургалт сурталчилгаа, үйл ажиллагаа хийхэд зориулалтын дагуу зохистой зарцуулалт хийж ажиллана. |
| 3.1 | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар 17 сая төгрөг | Тайлант онд байгууллагын нийт 49 албан хаагчаас 41 албан хаагчид 82 удаа 16,954.6 мянган төгрөгийн цалинтай чөлөө олгож, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. | Төсвийн тухай хуулийн 16.5.5-д зааснаар батлагдсан төсөвтөө багтаж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу албан хаагчдад цалингүй чөлөө олгож, хүндэтгэх шалтгаантай байдлыг ТЗУГ-аас хүний нөөцийн ажилтан нягтлан зарим үед цалинтай чөлөө олгож байна. |
| 3.1 | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газа 24.4 сая төгрөг | ГБХЗХГ-ын даргын 2023 оны А/84 дүгээр тушаалаар хүүхдийн эсрэнгийн, удирдлагуудыг чадавхжуулах сургалтад 18,095.0 мянган төгрөг, А/123 дугаар тушаалаар ажлын байрны стресс менежментийн дотоод сургалтад 6,288.0 мянган төгрөг, нийт 24,383.3 мянган төгрөгийг зарцуулж, үр ашиггүй, төвчиж болох зардал зарцуулсан байна. | Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл 7.1.6, 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, "Хүүхдийн эрхийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5, "Хүүхэд хамгааллын тухай" хуулийн 18 дугаар зүйл 18.1.7 дахь заалт, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны "Журам батлах тухай" хуулийг үндэслэн 21 аймаг, 9 дүүрэг, харьяа байгууллагын албан хаагчдад сургалт, хэлэлцүүлэг, арга хэмжээ сургалтыг зохион байгуулж ажилласан.Манай салбарын албан хаагчдын дунд хийсэн хүний нөөцийн судалгаагаар нийгмийн ажил, үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлдэг ажлын байр дахь албан хаагчдын 60 хувьд нь ажлаас халшрах хам шинж илэрсэн тул сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж ажилласан. |
| 3.1 | Хүүхэд хамгаалллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр 21.3 сая төгрөг | Багаж, техник хэрэгслийн зардлаас 12,768.5 мянган төгрөгийг байрны засварын ажилд, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 8,542.1 мянган төгрөгийг бичиг хэрэг, шатахуун, интернэтийн төлбөрт зарцуулж, зардлын ангилал зөрчиж зориулалт бус зардал гаргасан байна. | ХНХЯамны 2017 оны А/116 тушаал "Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам"-ын 2.3.3.1 дахь заалтуудыг үндэслэн Хүүхэд хамгаалллын хариу үйлчилгээ түр хамгаалах байр, Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүдэд урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх шаардлагаар нөхөн сэргээх байрыг ашиглалтанд оруулсан. Үүнтэй холбоотойгоор ХГБХХЁГ-ын даргын А/45 дүгаар тушаалаар батлагдсан 122,003.5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт олгогдсон. Нэмэлт санхүүжилтийг түр хамгаалах байрны үйл ажиллагаанд болон зөвлөгөө үйлчилгээ, шаардлагатай багаж, техник хэрэгсэлд бүрэн зарцуулсан. Зарцуулалт гаргах явцад Хүүхэд хамгаалллын хариу үйлчилгээ түр хамгаалах байрны зохицуулагчийн 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/07 тушаалаар батлагдсан төсвийн зардлын 2 зориулалт үйл ажиллагаанаас хамааран зөрсөн болохоор зарцуулалтыг бүрэн зарцуулсан болно. Хүүхэд хамгаалах хариу үйлчилгээ,түр хамгаалах байр нь 2 тусдаа байранд нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулан ажиллаж байна. Үйл ажиллагааны явцад хүүхдийн кейс болон байгууллагын ай хамтран үнийн судалгаа гаргаж өмч хамгаалах байгын зөвлөлд танилцуулан борлуулах ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна. 42 нэрийн 300.8 сая төгрөгийн материалыг шаардлага хангахгүй тул акталж, устгах үр дүн гарсан ба эдгээр бараа Хяналтын албанд нарийечлан шалгуулж цаг хугац |
| 3.1 | Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв 32.7 сая төгрөг | ХТ-ын 108 утасны үйлчилгээний төвийн захирлын 2023 оны А/13 дугаар тушаалаар баталсан программын аюулгүй байдал, ашиглалт хөгжүүлэлтийн зардлаас 316.5 мянган төгрөгийн хөдөөсөн пицца, бялуу, хиам, А/03 дугаар тушаалаар баталсан 108 утасны үйлчилгээний хэвийн үйл ажиллагаа хангах зардлаас 32,393.8 мянган төгрөгийг ахуйн болон хүнсний материалд зарцуулж, зориулалт бус зардал гаргасан байна. | Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв нь 24 цагаар эрсдэлт нөхцөлд буй хүүхдүүдийн дуудлага мэдээллийг хүлээн авах, эрсдэлт нөхцөлд буй хүүхдүүдэд шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлэн ажилладаг. Эрсдэлт нөхцөлд буй хүүхдүүдэд шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлэх явцад хүүхдүүдийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамруулах, цагдаагийн байгууллагатай хамтран ар гэрт нь эргэн нэгтгэн, шүүх шинжилгээний байгууллагын үзлэгт хамруулах гэх мэтээр 3-4 цагийн үйлчилгээ үзүүлдэг.<br>Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс шуурай тусламжийн үйлчилгээ үзүүлэхдээ Хөдөлмөр нийгмийн хамгаалллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2022 оны Хүүхэд хамгаалллын үйлчилгээний зардлын норматив батлах тухай А/23, А/27 тушаал, Хөдөлмөр нийгмийн хамгаалллын сайдын 2022 оны А/247 дугаар тушаалаар батлагдсан "Хүүхэд хамгаалллын үйлчилгээ үзүүлэх журам"-ын шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэх хэсгийн дагуу хүүхэд хамгаалллын багц бэлтгэн эрсдэлт нөхцөлд буй хүүхдүүдэд үйлчилгээг үзүүлдэг. Хүүхэд хамгаалллын багцад ахуйн зүйлс буюу нойтон салфетик, хуурай салфетик, нэг удаагийн бээлий, халаад хүүхдийн пампарс, нярайн сүү, 00 цаас гэх мэтээр бэлтгэн байгын бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Зориулалт бус зарцуулсан гүйлгээнүүд нь шуурхай тусламжийн үйлчилгээг хүүхдэд үзүүлэх явцад тооцоологуй гарсан зардлууд бөгөөд зөрчлийг дахин гаргахгүйгээр анхааран ажиллаж байна. |
| 3.1 | Чингэлтэй дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс 8.5 сая төгрөг | "Би хариуцлагатай аавээж" аяны хүрээнд хос цамц захиалан оёулсан боловч тухайн арга хэмжээндээ ашиглаагүй. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан | Арга хэмжээнд тухайн өдөрт нь хүлээлгэж өгөгүй дараа нь хүлээлгэн өгсөн зураг бичлэгээр хэлтсийн цахим хуудсаар батлагдаажуулсан тайлагнасан боловч шалгасан аудитор арга хэмжээнд зарцуулаагүй гэж зөрчилд авч албан шаардлага хүргүүлсэн. |
| 3.1 | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар 111.2 сая төгрөг | Агентлагийн батлагдсан бүтцийн нэгжид байхгүй Сургалт, судалгаа мэдээллийн төв нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 231 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын сайдын 2017 оны А/164 дүгээр тушаалын хүрээнд байгуулсан биеэ даасан төрийн үйлчилгээний төсвийн байгууллага боловч төсөв захиран зарцуулах эрхгүй. ХГБХХЁГ-ын нэгж хэлбэрээр үйл ажиллагаа явуулж нийт 8 албан хаагчийн цалин, урамшуулалд нийт 111,244.5 мянган төгрөгийг байгууллагын үндсэн цалингийн зардлаас зарцуулж, зардлын ангилал зөрчин төсвийн көрөнгийг зориулалт бусаар зарцуулж байна. | ССМТ Засгийн газрын 2017 оны оны 231 дүгээр тогтоолоор ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээнд байгуулагдаж ХНХС-ын 2017 оны А/164 дүгээр тушаалаар тус төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоо батлагдсан. ССМТөв нь хуулийн этгээдийн гэрчилгээтэй, тэмдэгтай боловч Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалллын ерөнхий газрын туслах үйл ажиллагааны зардалд тус төвийн цалингийн сан батлагддаг. Сургалт, судалгаа мэдээллийн төв нь тусдаа төсөвт байгууллага болох хүсэлтийг ХНХЯ-д хүргүүлэн ажиллаж байна. Жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэлд төрийн санд данс тооцоотой төсөвт байгууллага болгох талаар санал хүргүүлдэг. Хамтарсан ЗГ-ын зарим ямдын бүтэц ЗГ-ын 2024 оны 06 тогтоолоор батлагдсан тул агентлагийн бүтцийн саналд ССМТ-ийг харьяа байгууллагын статусаар ажиллуулах саналыг хүргүүлэхээр бэлтгэж байна. |
| 3.1 | Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 3.6 сая төгрөг | Батлагдсан төсвийг зориулалт бусаар, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй 3,566.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн | Зардлыг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна. |

| Асуулга | Зөрчлийн агуулга | Зөрчил үүссэн тайлбар | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|
| 3.1 | Сүхбаатар аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 17.4 сая төгрөг | Цалингийн сангийн хэмнэлтийг байгууллагын ахмадын сангийн дансанд төлөрүүлж төсвийн хэмнэлтийг зориулалт бус зарцуулсан. | Ахмадын сан байгуулан ажиллуулах 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурван хувиар сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө тусгаагүй" гэж үзэж албан шаардлага өгсөн. Иймд зөвлөмжийн дагуу залруулан шаардагдах хөрөнгийг төсөвтөө тусгаж ажиллаж байна. |
| 3.1 | ХЭДС болон харьяа байгууллага-2,100 сая төгрөг | | |
| 3.1 | Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 8 сая төгрөг | Тайлант онд олгосон санхүүгийн дэмжлэгийг зориулалт бусаар зарцуулсан./8,000.0 мянган төгрөг/ | Зориулалт бусаар зарцуулсан 1 иргэний 8000,0 төгрөгийг Нийслэл дэх төрийн аудитын дансанд төвлөрүүлсэн. |
| 3.1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 1,000.00 сая төгрөг | Уг гэрээний зорилго нь "Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, хөдөлмөр эрхлэгч иргэн, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид богино хугацааны зээлтийн хөрөнгийн санхүүгийн дэмжлэгийг шинэ технологи ашиглан цахим хэлбэрээр дамжуулан олгох" бөгөөд тайлант онд давхардсан тоогоор 6,812 иргэнд зээл олгосон байна. Энэ "Финтек /Аппликешны зээл/-ийг ашигласнаар хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн, шинээр ажлын байр бий болсон талаар тайлан, дүгнэлт хийгээгүй, хяналт хэрэгжүүлээгүй, үр дүнг тооцоогүй, дотоод хяналт сул байгаагаас төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй байна. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын 5.13, 5.14, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг 2022-2023 онд зохион байгуулах нэгдсэн удирдамж"-ын 3 дугаар хэсгийг 3.14 дэх хэсгийг тус тус үндэслэл болгон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж "Энт Кредит Инвестмент ББСБ" ХХК шалгарч 2023 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн ХХҮЕГ/24 дугаартай гэрээг 1 жилийн хугацаатай байгуулсан. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, бичил, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид богино хугацааны эргэлтийн хөрөнгийн, санхүүгийн дэмжлэгийг шинэ технологи (финтек) ашиглан цахим хэлбэрээр дамжуулан олгох үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, шийдвэрүүдэд нийцүүлэн зохион байгуулж ажилласан. Богино хугацааны эргэлийн хөрөнгийн хэмжээ нь 400,000-1,000,000 төгрөгийн хэмжээтэй тул ажлын байр хадгалах зорилгоор олгогдсон. Богино хугацааны зээл нь хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэдийн өдөр тутмын эргэлтийн хөрөнгө авахад зарцуулагдаг гэсэн тайлан Дархан-Уул аймаг, НХХГ-аас ирүүлсэн. 2023 оны жилийн эцсийн байдлаар хувиараа хөдөлмөр эрхлэгч 6812 иргэнд 3,249,990,000 төгрөгийн богино хугацааны эргэлтийн хөрөнгийн зээлийг олгосон Үүнээс Улаанбаатар хотод 5242 иргэнд 2,469,340,000 төгрөг, Дархан-Уул аймагт 1570 иргэнд 780,650,000 төгрөгийн зээл олгосон. |
| 4 | ЗТХС | Булган аймгийн БУЛГАН АЗЗА ТӨХК | Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 560,655.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 529,382.4 мянган төгрөгөөр давсан ба материаллаг алдаа, зөрчил нь тархалттай тул "Сөрөг" дүгнэлт өглөө. | ТӨБЗГ-ын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 04 тоот тушаалаар компанийн ерөнхий захирлыг албан тушаалаас нь чөлөөлсөн. |
| 5 | ХХААХҮС | Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК | Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлүүд нь санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө материаллаг бөгөөд түгээмэл тархсан байгааг үндэслэн "Сөрөг санал дүгнэлт" өгсөн. | Өмнөх оны аудитын албан шаардлага, зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн, алдаа зөрчлийг давтан гаргасан "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Цогтсаран, Ерөнхий нягтлан бодогч Б.Сосорбарам нарт тус тус сахилгын арга хэмжээ авлаа. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн тайлангийн 2023 оны аудитын шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар ХХААХҮЯамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тухай бүр хяналт тавин ажиллаж байна. |
| 6 | ЭМС | Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв | Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг цахим и-баримтгүй шилжүүлж, бүртгэлд тусгасан, ажилтнуудад Төрийн албан хаагчийн нэмэгдэл олгох журамд заагаагүй хариуцлагын нэмэгдлийг сар бүр олгосон, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зэрэг нийт 3,000,981.1 мянган төгрөгийн залруулаагүй зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. | Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв нь менежментийн хувьчлалаар хувьчлагдсан байгууллага бөгөөд өмчлөлийн маргаантай, емчийн асуудал шүүхийн байгууллагаар шалгагдаж байгаа тул хөрөнгө санхүүгийн тайланд тусгагддаг. |
| 7 | ЭМС | Баян-өлгий аймгийн Дэлүүн сумын ЭМТ | Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч ергөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна. | Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын Засаг даргын 2024 оны А/22 тушаалаар, Дэлүүн сумын ЭМТ-ийн даргын 2024 оны А/19 тушаалаар нягтлан бодогч Б.Ансаган цалингийн хувийг 3 сараар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан. |

| № | ТЕЗ | Байгууллагын нэр | Дүгнэлтийн үндэслэл | Хариуцлага тооцсон эсэх |
|---|---|---|---|---|
| 8 | ЭМС | Говь-Алтай аймгийн Зооноз өвчин судлалын төв | Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.<br>Санхүүгийн тайлангийн аудитаар сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин хот дотор автомашин ашиглан шатахуун зарцуулсан, ажилтнуудад шагнал, урамшуулал олгосон, ажлаас чөлөөлгөсөн албан хаагчидтай эзлжийн амралтын дуусгалтын тооцоог хийгээгүй, зардлын эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн, ажилчдын гарт олгосон цалинг зөрүүтэй тайлагнасан байна.<br>Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгээгүй, санхүүгийн тайланд өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, тусгаагүй, үнэ төлбөргүй орлогыг зөрүүтэй бүртгэсэн, шилэн дансны сайтад мэдээллийг бүрэн байршуулаагүй, төсвөөс цалингийн нөхөн олговор олгосон боловч бууутай этгээдээс нэхэмжлээгүй, Төрийн аудитын байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлээгүй зэрэг 864,787.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.<br>Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.4, 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, 22 дугаар зүйлийн 22.1, 24 дүгээр зүйлийн 24.4, 29 дүгээр зүйлийн 29.4, 41 дүгээр зүйлийн 41.12.2, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэхь заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. | Говь-Алтай аймгийн Зооноозын өвчин судлалын төвийн даргаар 2023 онд ажилласан Р.Наранбаатарыг Говь-Алтай аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 112/ШШ2023/0009 дугаартай шийдвэрийн дагуу 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн Б/107 дугаар тушаалаар ажлаас чөлөөлсөн байна. |
| 9 | ЭМС | Говь-Алтай аймгийн Дарви сумын ЭМТ | Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 1а/3135 албан бичгээр аймгийн Засаг даргад албан бичиг хүргүүлсэн боловч хариу ирээгүй байна. |
| 10 | ЭХС | Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК | Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор материаллаг шинж чанартай 1,704.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Аудитаар тендерийн болон тендерийн бус 538.1 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа зохицуулалтын шинж чанартай байгаа тул хуулийн хэрэгжилтийн байгууллагад шилжүүлэх. | Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлт өгч ТУЗ-ийн 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 20 дугаар тогтоолоор 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс чөлөөлөгдсөн. Ерөнхий нягтлан бодогч Д.Гэрэлчулуун нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгч, ажлаас чөлөөлөгдсөн. |

**Орон нутгийн ТЕЗ харьяа байгууллагаас сөрөг дүгнэлт**

| № | ТЕЗ | Байгууллагын нэр | Дүгнэлтийн үндэслэл | Хариуцлага тооцсон эсэх |
|---|---|---|---|---|

**Орон нутгийн ТЕЗ харьяа байгууллагаас сөрөг дүгнэлт**

| № | ТЕЗ | Байгууллагын нэр | Дүгнэлтийн үндэслэл | Хариуцлага тооцсон эсэх |
|---|---|---|---|---|
| 1 | Архангай аймаг | Эрдэнэмандал сумын "Шилмэл сүргийн үржлийн төв" ОНӨААТҮГ | Санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагад тайланд онд 15.2 сая алдагдалтай ажилласан, жилийн эцсийн санхүүгийн тайланд эргэлтийн сүргийн мал амьтан дансанд 468 толгой малыг 96.8 сая төгрөгөөр буртгэснийг тодруулга тайланд нас, зүс, зэмэгний дугаараар дэлгэрэнгүй бүртгээгүй, баримтжуулаагүй, малын "А" данс, нярвын тайлангууд зөрүүтэй, 3.2 сая төгрөгийн зарлагын гүйлгээ нь цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй, анхан шатны баримтын шаардлагыг хангахгүй, хэлтүүлэгч мал түрээслүүлэх гэрээний дагуу 1.1 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн, санхүүгийн тайланд авлагаар бүртгэж тайлагнаагүй, сумын ОНХС-аас 5.7 сая төгрөгийн дэмжлэг авч зориулалтын дагуу зарцуулаагүй, компаний Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2023 оны орлого, эх үүсвэр болон ашиг алдагдлыг батлаагүй зэрэг зөрчил илэрсэн нь материаллаг бөгөөд ерөн тархсан тул "Сөрөг дүгнэлт" өгөв. | Эрдэнэмандал сумын шилмэл сүрэг ОНӨААТҮГ-ыг Архангай аймгийн Эрдэнэмандал сумын иргэдийн төлөөлөгч хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн 13 дугаар тогтоолоор татан буулгасан. Мөн аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн б/26 дугаар захирамжаар Эрдэнмандал сумын Засаг дарга Н.Лхагвадоржийг үүрэгт ажлаас огцруулсан байна. |
| 2 | Баянхонгор аймаг | Буцагаан сумын ЗДТГ | Аудитаар 117,904.0 мянган төгрөгийн 4 алдааг санхүүгийн тайланд залруулсан. Аудитаар 322,299.1 зөрчил 15 илэрснээс 7,056.4 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 218,035.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 97,207.1 мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж өгсөн. Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 261,667.5 мянган төгрөгийн материаллагаар тооцсон залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 254,241.3 мянган төгрөгөөр их, материаллаг ба өргөн тархсан тул "Сөрөг" дүгнэлт өгсөн. | Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн Б/07-ны өдрийн дугаар захирамжийн дагуу Засаг даргын Тамгын газрын дарга Л.Бүрнээбаатарт сахилгын шийтгэл оногдуулан МУЗЗНДНТУТХ-ийн 59.1.22, Төрийн албаны тухай хуулийн 48.1.4 дэх заалтуудыг үндэслэн ажлаас бүрэн чөлөөлсөн. |
| 3 | Говь-Алтай аймаг | Есөнбулаг сумын ЗДТГ | Санхүүгийн тайлангийн аудитаар зэлжийн амралт цалин давхардуулан олгосон, өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтны тэтгэмжийн илүү, дутуу тооцон олгосон, эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн, цалингийн зардлаас үйлдвэрчний эвлэлийн татвар суутгаж шилжүүлээгүй, нярав, нягтлан бодогчийн дансаар дамжуулан гүйлгээ хийсэн, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгээгүй, хөрөнгийг дансны ангилал зөрүүтэй бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгө бараа материалыг орлогод авааагүй, санхүүгийн тайланд авлага, өглөгийг тусгаагүй, газрыг үнийн дүнг зөрүүтэй бүртгэсэн, Засаг даргын нөөц хөрөнгөөс бэлэг дурсгал, туршлага солилцох зардлыг санхүүжүүлсэн, шилэн дансны сайтад мэдээллийг бүрэн байршуулаагүй, төсвөөс автомашины торгууль төлсөн, тесел арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ажлын даалгаврыг боловсруулаагүй, авлагыг барагдуулаагүй. Төрийн аудитын байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлээгүй 1,519,416.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна | Ажилтнуудад олгосон илүү цагийн цалинг 2024 оны 06 сарын цалин дээрээс суутгаж баримтыг программд хавсаргаж, биелэлтийг төрийн аудитын байгууллагад хүргүүлсэн. Ажилчдаас суутгасан боловч үйлдвэрчний эвлэлийн шилжүүлээгүй 766.1 мянган төгрөгийг шилжүүлсэн баримтыг программд оруулж хөрөнгө материалын тооллогыг 1-р улиралд комисс томилон зохион байгуулж актлах болон, дахин үнэлэх, хөрөнгийг ангилан ялгаж аймгийн орон нутгийн емчийн газарт хүргүүлсэн. Мөн хөрөнгө материалыг сар бүр нярвын тайлантай тулган баталгаажуулж орлогодож, зарлагадан ажиллаж байна. Авто машины торгуулийг байгууллагын данснаас төлсөн зөрчлийг холбогдох тайлбарын хамт аудитын цахим системд оруулсан. Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Батцэцэг , Санхүүгийн албаны дарга А.Алтанцэцэг, Төсөв төрийн сангийн мэргэжилтэн Н.Базаррагчаа. Тамгын газрын нярав З.Бүрэнтөгс нарт хариуцлага тооцож арга хэмжээ авсан. Төрийн Аудитын газарт хариуг хүргүүлэн ажилласан. |
| 4 | Говь-Алтай аймаг | Есөнбулаг сумын ИТХ | Санхүүгийн тайлангийн аудитаар авлага өглөгийн тооцоо нийлээгүй, барагдуулах арга хэмжээ авдаггүй, нярвын тайлан гаргаагүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн, түлээ нүүрсний хөнгөлөлтөөс хувь хүний орлогын албан татвар суутгаагүй, цалингийн зардлаас олон нийтийн цагдаагийн цалин олгож зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан, ажилтнуудад цалинг илүү тооцож олгосон, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны зардлыг олгохдоо анхан шатын баримтад үндэслээгүй, санхүүгийн тайланд нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын өр авлагыг тайлагнаагүй, шилэн дансны мэдээллэл хангалтгүй оруулсан, емнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй, давтан гаргасан зэрэг 212,618.0 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.4,16.5.5, 57 дугаар зүйлийн 57.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.4, 6 дугаар зүйлийн 6.3.2, 16 дугаар 16.5.7 заалт, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолын 3 дугаар 3.7, заалт, хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 14 дүгээр зүйлийн 14.1, 17 дугаар 17.1.1 заалт, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5 дахь заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй | Нүүрсний хөнгөлөлтөөс дутуу суутгасан 50000 төгрөгийн төлбөрийг төлүүлж, хариуг аудитын газарт хүргүүлсэн. Мөн хөрөнгө материалын тооллогыг 1-р улиралд комисс томилон зохион байгуулж актлах болон, дахин үнэлэх, хөрөнгийг ангилан ялгаж аймгийн орон нутгийн емчийн газарт хүргүүлсэн. Хөрөнгө материалыг сар бүр нярвын тайлантай тулган баталгаажуулж орлогодож, зарлагадан ажиллаж байна. Ажилтнуудад илүү бодож олгосон цалинг төлүүлэх талаар нягтлан бодогчоор ажиллаж байсан Ц.Одмандахтай ИТХ-ын НБД Н.Бүрэнчөдөр 2 удаа холбогдож мэдэгдэл хүргүүлсэн. Гүйлгээний анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн зөрчлийг 2024 онд дахин давтан гаргахгүй тал дээр ажиллаж шат шатны хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Шилэн дансны мэдээллийг улирал бүр бүрэн хөтөлж, хуулийн хугацаанд программд оруулж байна. Сумын санхүүгийн албаны 1, 2-р улирлын шилэн дансны хэрэгжилтээр шалгуулан мэдээллийг бүрэн байршуулсан. |

121

| № | ТЕЗ | Байгууллагын нэр | Дүгнэлтийн үндэслэл | Хариуцлага тооцсон эсэх |
|---|---|---|---|---|
| 5 | Дундговь аймаг | Дундговь- Ус ОНӨААТҮГ | Санхүүгийн тайлан дахь 218.2 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй 57.8 сая төгрөгийн ажил гүйлгээ хийсэн зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/, 20 дугаар зүйлийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1-т /Худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээнэ/, мөн иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. | 2023 оны 12 сарын 31-нээрх 218.2 сая төгрөгийн авлагыг 2024 оны 06 сарын 30-ны байдлаар харилцагч байгууллагуудтай тооцоо нийлэн баталгаажуулж, авлага барагдуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна<br>Иргэн хуулийн этгээдээс гэрээ байгуулаагүй, пүүний бичиггүй худалдан авсан 57.8 сая төгрөгийн нүүрс худалдан авалтыг хууль хяналтын байгууллагаар шалгуулж, тухайн үеийн орон нутгийн пүүн дээр пүүлсэн пүүний баримт бичгүүдийг гаргуулан авсан.<br>Захирал О.Бархүүд Аймгийн засаг даргын 2024 оын 04 сарын 12-ны өдрийн Б/09 тоот захирамжаар цалингийн 20 хувиар сахилгын шийтгэл ноогдуулсан. |
| 6 | Завхан аймаг | Дөрвөлжин ЗДТГ | Дөрвөлжин сумын Засаг даргын Тамгын газар нь шатахуун зардлыг нормоос илүү зарцуулсан, зардлыг зориулалт бусаар зарцуулсан, орон нутгийн төсвөөс нэмэлт төсөв хуваарилсан, засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан, цалин амралтын мөнгийг алдаатай тооцоолон олгосон байна. | Дөрвөлжин сумын Засаг даргын 2024-05-20 өдрийн Б/09 тоот захирамжаар ЗДТГ-ын дарга В.Уранчимэгт сануулах сахилгын шийтгэл ноогдуулсан байна. |
| 7 | Завхан аймаг | Түдэвтэй ЗДТГ | Түдэвтэй сумын Засаг даргын Тамгын газар нь Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан, бараа материалын тайланг үнэн зөв гаргаагүй, шатахууны зардлыг үрэлгэн зарцуулж, жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, жилийн эцсийн тооллогыг зохион байгуулаагүй байна. | Түдэвтэй сумын Засаг даргын 2024-06-26 өдрийн А/76 тоот захирамжаар ЗДТГ-ын дарга Д.Бадамхандад сануулах сахилгын шийтгэл ноогдуулсан байна. |
| 8 | Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч | Нийслэлийн нийтийн тээврийн газар | Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй, аймгуудын ЗДТГ-аас нийтийн тээврийн хэрэгслийн цахим картаар үнэ төлбөргүй зорчсон хөдөө, орон нутгийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нөхөн олговрын авлагыг барагдуулаагүй, бүртгэл тайланд тусгаж, тайлагнаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийсэн, гэрээг цуцалсан авлагыг урьдчилж гарсан зардлаар тайлагнасан, захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зэрэг нийт 2,562,939.1 мянган төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуультай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "иж бүрэн байх", "үнэлгээ ба хуваарилалт", "эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. | Нийслэлийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн Б/99 захирамж, Нийслэлийн тээврийн бодлогын газрын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Б/272 дугаар тушаалаар тус газрын дарга болон ахлах нягтлан бодогч нар солигдсон тул тухайн хугацаанд хариуцан ажиллаж байсан албан тушаалтнуудад хариуцлага тооцоогүй болно. Тухайн албан шаардлагатай холбоотой тооцоог аж ахуйн нэгж байгууллагуудад 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01/06/03 -01/06/17 дугаартай албан бичгүүдээр үүссэн авлагыг яаралтай барагдуулж ажиллахыг мэдэгдсэн. |

| № | ТЕЗ | Байгууллагын нэр | Дүгнэлтийн үндэслэл | Хариуцлага тооцсон эсэх |
|---|---|---|---|---|
| 9 | Орхон аймаг | Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ААТҮГ | 1. Томилолтоор явсан нь дэмжигдэхгүй баримтаар 32.9 сая төгрөгийн томилолтын зардал олгосон байна.<br>2. Цахим-Эрдэнэт-1 төслийн хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн 60.0 сая төгрөгийн зардлын зарцуулалт анхан шатны нотлох баримтгүй, зардлыг төсвийн хүрээнд зарцуулсан нь нотлогдохгүй байна.<br>3. Нотлох баримтаар ажил хийгдсэн нь нотлогдохгүй ухаалаг хотын сурталчилгаа хийлгэх зардал 5.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.<br>4. Нотлох баримтаар ажил хийгдсэн нь нотлогдохгүй гэрээт ажлын хөлс 3.0 сая төгрөг хувь хүний дансанд шилжүүлсэн байна.<br>5. 2022 оны санхүүгийн тайланд өглөөөр тусгаагүй цахилгааны төлбөр 1.1 мянган төгрөгийг тайлант онд шилжүүлсэн байна.<br>6 Харилцагч байгууллагуудтай тооцооны үлдэгдлийн баталгааг үйлдээгүй байна | 1. Аудитын явцад албан томилолтын зардлын анхан шатны баримтыг нехөн бүрдүүлсэн. 2. Цахим Эрдэнэт-1 төслийн зардлын зарцуулалтын анхан шатны баримт бүрдэл хангалтгүй байгаа тухай албан шаардлага хүргүүлсэн боловч, биелэлт ирүүлээгүй. Тус байгууллагын ТУЗ-ийн 2024.05.03-ны едрийн хурлаар төлбөрийн актыг гүйцэтгэх захирал Н.Энхбаяр, нягтлан бодогч Д.Гүрсүрэн нараар төлүүлж, сахилгын шийтгэл /сануулах/ арга хэмжээ авах шийдвэр гаргасан. 3. Нотлох баримтгүй 5000.0 сая төгрөгт төлбөрийн акт тогтоож, орон нутгийн хүү торгуулийн дансанд 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр төлж бөрагдуулсан. 4. Баримтаар нотлогдоогүй 3000.0 сая төгрөгийн ажил гүйлгээнд төлбөрийн акт тогтоож 2024 оны 5-р сарын 16-ны өдөр Орон нутгийн хүү торгуулийн дансанд төвлөрүүлсэн. 5. Үүссэн өр төлбөрийг тухай бүрт өглөг, авлагаар бүртгэж, тайлант хугацааны эцэст санхүүгийн тайланд бүрэн тусгаж, өр төлбөрийг барагдуулж байх зөвлөмж өгсөн. Хагас жилээр биелэлт ирүүлсэн. 6. Харилцагч байгууллагуудтай тайлант оны эцэст авлага, өглөгийн тооцоо нийлж, тооцооны үлдэгдлийн баталгаа үйлдэж баталгаажуулж, санхүүгийн тайланд тусгаж байх зөвлөмж хүргүүлсэн. |
| 10 | Өвөрхангай аймаг | Өв Эко Мийт ХХК ТӨА | 1. Өв Эко мийт ОНӨ ХХК ний гүйцэтгэх захирал нь удирдах зөвлөлтэй гэрээ байгуулаагүй, ажлыг нь үнэлж дүгнэдэггүй. Удирдах зөвлөл нь 2022 оны санхүүгийн тайланг батлаагүй, дотоод хяналт хангалтгүй.<br>2. Нягтлан бодогч нь ажлаа хүлээлгэж өгөхдөө санхүүгийн болон анхан шатны баримт хүлээлгэж өгөөгүй, анхан шатны баримтууд байхгүй<br>3. Өглөг авлага нь тодорхойгүй, харилцагч аж ахуй нэгж байгууллага, иргэнтэй өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,<br>4. Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодоогүй зэрэг нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.1, 18 дугаар зүйлийн 18.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-дэх хэсгийн 76.1.9, 76.1.11-дэх заалт, СТОУС-11,16 заалтад нийцэхгүй, Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Толилуулга ба тодруулга, Үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна. | 1. Өв Эко мийт ОНӨ ХХК-ийн ТУЗ-ийг 2024 оны 6-р сард шинэчлэн байгуулсан. 07-р сард ТУЗ хуралдаад түрээсийн гэрээ болон бусад зүйлийг хангалтгүй гэж дүгнэзд захиралд үүрэг даалгавар өгч ажилласан. 8-р сард дахин хуралдаж Дэлхийн хүнс ХХК-тай түр гэрээ байгуулан ажиллаж байна.<br>2. 2023 оны 12-р сард шинээр нягтлан бодогч томилсон. Компанийн санхүүгийн үйл ажиллагааг хэвийн явуулж байна.<br>3. 2023 оны өглөг, авлагын тайланг нехөн гаргаж, тайланд тусган ажиллаж байна.<br>4. 2024 оны 6-р сард бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийж, тооцоог бодсон. |
| 11 | Өмнөговь аймаг | Тавантолгой ХК | Санхүүгийн тайлангийн аудитаар борлуулалтын орлого дутуу бүртгэсэн, өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, шатахууны норм хэтрүүлэн зарцуулсан, хөрөнгийг шууд зардалд бүртгэсэн, цалин, нэмэгдэл илүү олгосон, нэмэлт гэрээ байгуулсан, гэрээний хэрэгжилт тооцоогүй, шууд болон гэрээ байгуулаагүй худалдан авалт хийсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ хийсэн, өмнөх оны санхүүгийн тайланг программаар гаргаагүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хүрээнд зохион байгуулаагүй зэрэг нь Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Компанийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Төрийн аудитын тухай хуулийн холбогдох заалтууд болон НББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" стандарттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, толилуулга, ангилал, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. | Таван толгой ХК нь 2023 оны аудитаар сөрөг дүгнэлт авсан. Иймд компаний ТУЗ-аас тогтоол гарган 2022-2023 оны санхүүгийн тайланд дахин хөндлөнгийн аудит хийх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байна.Энэхүү зөвлөх үйлчилгээ болон аудитын үйл ажиллагаа 2024 оны 11-р сарын 15-нд дуусгавар болох гэрээтэй ажиллаж байна. |

| № | ТЕЗ | Байгууллагын нэр | Дүгнэлтийн үндэслэл | Хариуцлага тооцсон эсэх |
|---|---|---|---|---|
| 12 | Сүхбаатар аймаг | Сүхбаатар аймаг Бичигт хөгжил ОНӨААТҮГ | Тайлант оны өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хийж, тайланд илэрхийлсэн, нийгмийн даатгалын тайланг үнэн зөв тайлагнаагүй, бараа материалын тайлан гаргаж баталгаажуулаагүй, шилэн дансны цахим системд бүртгүүлэн мэдээллийг ил тод байршуулж мэдээлээгүй, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын систем хэрэгжихгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тайлант хугацааны ажил гүйлгээний анги, дансны үлдэгдлийн холбогдох тодруулгын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. | "Бичигт хөгжил" ОНӨААТҮГ-ын захирал Н.Ариунтунгалаг нь албан үүргээ хангалтгүй биелүүлж, санхүүгийн зөрчил гаргасан нь Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын хяналт, шалгалтаар тогтоогдсон тул 2024 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн Б/35 тоот аймгийн Засаг даргын захирамжаар сануулах шийтгэл ногдуулсан болно. |
| 13 | Ховд аймаг | Аймгийн ЗДТГ | Бэлтгэн нийлүүлэгч, гүйцэтгэгчидтэй тооцоо нийлж, авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, авлага өмнөх оноос өссөн, бараа материал, хөрөнгийн тооллого хийгээгүй, байгууллагын эзэмшилд байсан тээврийн хэрэгсэл бодитоор оршин байхгүй, шатахууны тооцоог бодоогүй, замын тооцооны хуудас хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ гаргасан, Засаг даргын захирамжид зааснаас илүү хөрөнгө зарцуулсан, санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй, 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн. | Хариуцлага тооцоогүй тухайн үед албан тушаал хашиж байсан дарга нягтлан бодогч нар нь ажлаа өөрчилж өөр албан тушаалд шилжин ажилласан, ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч байсан Б.Баярсүх Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргаар, ерөнхий нягтлан бодогч Б.Нямдэлгэр Жаргалант сумын орлогч даргаар ажиллаж байна. |
| 14 | Ховд аймаг | Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци | Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг ТУЗ-аар батлуулаагүй, Хувийн хэвшлийн компанийг эрх шилжүүлэх болон худалдан авах гэрээ байгуулан өөрийн эзэмшилдээ шилжүүлэн авсан, санхүүгийн тайланд орлогыг зөрүүтэй тайлагнасан, бусад байгууллагад хандив өгсөн, бие даасан хуулийн этгээдэд санхүүжилт олгосон, хөрөнгө борлуулсны орлогыг холбогдох байгууллагад дутуу төвлөрүүлсэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан, бараа материалыг орлогод авч тооцоог бодоогүй зэрэг зөрчлүүд илэрсэн | Хариуцлага тооцоогүй тухайн үед албан тушаал хашиж байсан захирал нягтлан бодогч нар нь ажлаа өөрчилж өөр албан тушаалд шилжин ажилласан. Захирал Ш.Батжаргал орон нутгийн сонгуульд нэр дэвшихээр болж ажлаас чөлөөлөгдсөн, нягтлан бодогч нь өөрийн хүсэлтээр ажлаас гарсан. |
| 15 | Хөвсгөл | Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар | Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:<br>1. Байгууллагын нягтлан бодогч нь 2023 оны 2 дугаар улирлын 1,785,072.4 мянган төгрөгийн орлого, зарлагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэхдээ ажил, гүйлгээ бүрээр хөтлөөгүй, орлого, зарлагыг бөөн дүнгээр журналд бичиж бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нь нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө" заалттай тус тус заалттай нийцээгүй ба "иж бүрэн", "тасалбар болголт" гэсэн батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.<br>2. Төсвийн хөрөнгөөр 2023 онд 345.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн, томилолтын ажлын зорилго, удирдамж нь тухайн албан хаагчийн ажлын чиг үүрэг, албан тушаалд хамааралгүй байхад 2,500.0 мянган төгрөгийн гадаад томилолтын зардлыг олгож, төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулсан. Энэ "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцээгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.<br>Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй. | Байгууллагын нягтлан бодогч Д.Балжинням нь ажлын шаардлага хангахгүй байсан тул 2024-01 сард ажлаас чөлөөлсөн бол, Тамгын газрын дарга Э.Улам-Өсөхийг 2024-03-24-ний өдрийн Б/18 тоот тушаалаар ажлаас нь чөлөөлсөн. Шинээр томилогдсон нягтлан бодогч болон Тамгын газрын даргад ажлаа үр дүнтэй төлөвлөн хууль дүрэм журам, стандартад нийцүүлэн ажиллахыг үүрэг болгосон. ЗДТГ-ын нийт албан хаагчдад Төрийн хэмнэлтийн тухай хуулийнд төсөв, хөрөнгөтэй холбоотой тусгагдсан заалтуудыг танилцуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах талаар мэдээллийг өгнө. Хэрэгжилтийг улирал бүр гаргаж, байгууллагын өглөөний сонсголд мэдээлж ажиллаж байна. Тавигдсан актыг эхний хагас жилд багтаан холбогдох албан хаагчдаар төлүүлэн актын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. |

Асуулга 5 болон 7 - Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.3 дахь хэсэгт "Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн төсөвт тухай хуульд заасан зардлыг хэтрүүлсэн, ангилал зөрүүлсэн, зориулалт бусаар ашигласан бол тухайн эрхэлж байгаа албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно" гэж заасны дагуу харилцлага тооцсон албан тушаалтнуудын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

САНАЛ, ДҮГНЭЛТ ӨГӨХӨӨС ТАТГАЛЗСАН

| № | ТЕЗ | Байгууллагын нэр | Харилцлагын хэлбэр /ТЕЗ, ТТЗ, ТБОНӨҮГ, ТХН,ТШЗ, ЗГТС/ | Дүгнэлтийн үндэслэл | Харилцлага тооцсон тухай тайлбар |
|---|---|---|---|---|---|
| **Улсын төсвийн ТЕЗ харьяа байгууллагаас дүгнэлт өгөхөөс татгалзсан** | | | | | |
| 1 | БШУС | Булган аймаг дахь МСҮТ | ТШЗ | Санхүүгийн тайлант хугацаанд ирүүлээгүй. Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай гэрээ хийгээгүй, тооцоо нийлсэн акт байхгүй. Бараа материалын нярвын тайлан бараа материалын тодруулга тайлангаас орлого 695.0 мянган төгрөг, зарлага 1,553.8 мянган төгрөгөөр илүү, үлдэгдэл 96.0 мянган төгрөгөөр дутуу. Захирлын 2023 оны 12 дугаар сарын 08-ны А/89 дүгээр тушаалаар тооллогын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон бөгөөд тооллогын комиссын ажлын тайланд 2,893,007.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 332,369.0 мянган төгрөгийн бараа материалыг тус тус тооцсон гэж тусгасан нь санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаас 595,750.3 мянган төгрөгөөр дутуу, бараа материалын тодруулга тайлангаас 4,995.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. Тооллогын тооцоо бодсон баримтад тооллогын комиссын гишүүд бүрэн батлагаажуулаагүй. Үйл ажиллагааны орлого 4,580.0 мянган төгрөгийг бүрдүүлж улсын төсөвт төвлөрүүлсэн ч 250.0 мянган төгрөгийн орлогын анхан шатны баримтгүй, МСҮТ-ийн захирлын 2016 оны А/56 дугаар тушаалаар батлуулсан "МСҮТ-ийн танхимын болон үйлдвэрлэлийн дадлага ажлыг зохион байгуулах журам"-ын 3.4-т 1-р курсээс бусад ангийн хичээл үйлдвэрлэлээс зарцуулж буй материалын зардлын 30-50 хувийг буцааж төвлөрүүлэхээр заасан ч тайлант хугацаанд төвлөрүүлсэн орлого байхгүй, албажуулсан тооцоолол анхан шатны баримт байхгүй, холбогдох албан хаагчдаас авлага үүсгээгүй, Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 691.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн ч тайлан буртгэлд тусгаагүй, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, Нягтлан бодогч аудитын тогтоосон хугацаанд ирээгүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 72 дугаар зүйлийн 72.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.6, УСНББОУС-1, 12, 17, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна. | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Булган аймаг дахь МСҮТ-ийн захирал Д.Баттуяаг БЕГ-н даргын 2023 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн Б/376 тоот тушаалаар ажлаас чөлөөлсөн. Нягтлан бодогчид сахилгын шийтгэл оногдуулсан болно. |
| 2 | ХНХС | Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс | ТШЗ | Санхүүгийн тайлан бүрэн илэрхийлэгдсэн мөн хуулийн хугацаа хоцроон дүгнэлт олгох сүүлийн өдөр тайлангаа ирүүлсэн. | Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалллын газар нь 2023 оны санхүүгийн тайланг 2023 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 58 дугаар албан бичгээр хугацаа хоцроож ирүүлсэн. төсвийн гүйцэтгэлийн тайлан, нэмэлт санхүүжилтийн тайланг тайлбарын хамт ирүүлээгүй. Дорнод аймгийн Төрийн аудитын газраас тус байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд "Татгалзсан" дүгнэлт өгсөн бөгөөд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалллын ерөнхий газрын, өдрийн 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Б/38 дугаар тушаалаар Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалллын газрын дарга Э.Жавхланд албан тушаалын цалингийн хэмжээг 2 сарын хугацаагаар 15 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан байна. |
| 3 | ЭМС | Төв аймгийн Баянжаргалан сумын эрүүл мэндийн төв | ТШЗ | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан | Төв аймгийн Эрүүл мэндийн төвийн дарын 2024 оны Б/02 тушаалаар нягтлан бодогч С.Болормаад сануулах сахилгын шийтгэл ногдуулсан. |
| 4 | ЭМС | Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүн эмнэлэг | ТШЗ | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 1А/3137 албан бичгээр аймгийн Засаг даргад албан бичиг хүргүүлсэн боловч харуу ирээгүй байна. |
| 5 | ЭМС | Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төв | ТШЗ | Төв аймгийн Баянцагаан сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны Санхүү байдлын тайлан, Санхүүгийн тайлангийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаагүй. Төсвийн шууд захирагчаар батлагаажуулан, хуулийн хугацаанд бэлтгэн хүргүүлээгүй.<br>Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх"; гэж заасныг, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. | Төв аймгийн Эрүүл мэндийн төвийн дарын 2024 оны Б/07 тушаалаар нягтлан бодогч П.Очир-Өлзийг сануулах сахилгын шийтгэл ногдуулсан |
| **Орон нутгийн ТЕЗ харьяа байгууллагаас дүгнэлт өгөхөөс татгалзсан** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Архангай аймаг | Эрдэнэмандал сумын "Ар сараач" ОНӨААТҮГ | ТБОНӨҮГ | "Мал нядлагааны газар болон мах боловсруулах үйлдвэр байгуулах" төсөл хэрэгжүүлэхээр 2023 оны 05 дугаар сарын 04-нд сумын Хоршоо хөгжүүлэх сангаас 66.0 сая төгрөгийн зээлийг хүүлийн эргэздийн дансвар дамжуулсан. Зээлийн 6.0 сая төгрөгийг хүс газрын захирлын дансанд. 60.0 сая төгрөгийг хувь хүний дансанд шилжүүлсэн. Хоршоо хөгжүүлэх сангаас авсан зээлийн хөрөнгийг тайлант оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд мөл амьтадын үлдэгдлээр, жилийн эцэст үлдэгдэлгүй тайлагнасан зээргийг аудитаар нотлох боломжгүй тул Дүгнэлт өгөхөөс татгалзсан. | Архангай аймгийн төрийн аудитын газрын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 332/А/0360217 дугаар албан шаардлагын дагуу Ар сараач ОНӨААТҮГ-ын захирал Л.Гансүхийг Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн б/03 дугаар захирамжаар ажлаас халсан. Мөн аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн б/26 дугаар захирамжаар Эрдэнэмандал сумын Засаг даргаНЛхагвадоржийг үүрэгт ажлаас огцруулсан байна. |
| 2 | Архангай аймаг | "Цем сүргийн үржлийн төв" ОНӨААТҮГ | ТБОНӨҮГ | Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанаас 35 хоногийн дараа буюу 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн хэдий ч аудитад шаардагдах анхан шатны баримтуудыг ирүүлээгүй хангалттай зохистой аудитын нотлогоо олж авах боломжгүй байсан тул дүгнэлт өгөхөөс татгалзсан. | Цем сүргийн үржлийн төвийн захирал Е.Дэлгэрцогтыг аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын б/19 дугаар захирамжаар ажлаас халсан. |
| 3 | Булган аймаг | "Эмийн цэцэглэн" ББН өрхийн эрүүл мэндийн төв | ОНӨААТҮГ | Жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй, санхүүгийн тайлан гаргахдаа журнал, бүртгэлийг нийт дүнгээр хөтөлсөн, бэлтгэн нийлүүлэгч байгуулагдуудтай тооцоо нийлсэн актгүй, НББ-ийн тухай хуулийн 6.1, 13.1, 13.6, 13.7, 18.1, 20.2.5, ТБОНӨ-ийн тухай хуулийн 70.2, 72.4, төсвийн тухай хуулийн 8.9.8, Нөхөрлөлийн тухай хуулийн 22, УСНББОУС-1, 12, 17 дахь заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. | Өрхийн эмнэлэг нь нөхөрлөлийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг, хариуцлага тооцох тухай Аудитын албан шаардлагыг нөхөрлөлийн хурлаар хэлэлцэж байгуулагын дарга, нягтлан бодогчид сахилгын арга хэмжээ тооцсон. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлж ажилласан. |
| 4 | Булган аймаг | "Цоожэд" ӨЭМТ | ОНӨААТҮГ | Жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй. CTS санхүүгийн программ бүртгэл хөтлөөгүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлсэн актгүй, үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн ч тушаал шийдвэргүй, НББ-ийн тухай хуулийн 6.1, 13.1, 13.6, 13.7, 18.1, 20.2.5, ТБОНӨ-ийн тухай хуулийн 70.2, 72.4, төсвийн тухай хуулийн 8.9.8, Нөхөрлөлийн тухай хуулийн 22, УСНББОУС-1, 12, 17 дахь заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. | Өрхийн эмнэлэг нь нөхөрлөлийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг, хариуцлага тооцох тухай Аудитын албан шаардлагыг нөхөрлөлийн хурлаар хэлэлцэж байгуулагын даргад санхүүгийн үйл ажиллагаанд хянаалт тавьж ажиллахыг даалгаж, нягтлан бодогчид сахилгын арга хэмжээ тооцсон. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах төлөвлөгөө гаргаж батлан хэрэгжүүлж ажилласан. |
| 5 | Булган аймаг | Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй ОНӨХХК | ОНӨААТҮГ | Өвс тэжээлийн 14.4 сая төгрөгийн 16 тн тэжээлийг дутуу нийлүүлсэн. аймгийн ИТХ-аар батлагдсан "Худалдан авах ажилпагааны төлөвлөгөө"-нд тусгагүй 33.7 сая төгрөгийн цахилгаан дамжуулах агаарын шугам бэлтгэсэн. 121.5 сая төгрөгийн орлого тасарсан. 13,9 сая төгрөгийг гэрээ байгуулагүй "Киберзаал" ХХК-ны дансанд шилжүүлсэн, 21 бярууны 9 4, 598,3 сая төгрөгийн 4 трактөрын эргэн төлөлтийг тус тус авлагаар тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 41.2.1, ТБОНӨ-ийн тухай хуулийн 72.4.1, 73.2, НББ-ийн тухай хуулийн 13.5, 13.6, 13.7, 14.4.2, 14.5, 20.2.5, 20.2.6, Төрийн аудитын тухай хуулийн 35.1 дэх заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. | Байгууллагын удирдлага Төрийн аудитын байгууллагын татгалзсан дүгнэлт болон актыг хүлээн зөвшөөрөөгүй, захиргааны хуулийн дагуу сонсох ажиллагаа хийгээгүй гэж үзсэн. Авлигатай тэмцэх газраас шалгалт хийж, дутуу нийлүүлсэн өвс тэжээл, бярууны үнийг холбогдох албан тушаалтнаар төлүүлэхээр шийдвэрлэсэн. ХААХИОНӨААТҮГ-ын захирал чөлөөлөгдсөн. |
| 6 | Говь-Алтай аймаг | Марал-Алтай ӨЭМТ | ТШЗ | Аудитаар санхүүгийн тайланд тусгасан өглөг, авлагын тооцоо нийлээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй, нягтлан бодох бүртгэлийг стандарт, зааварын дагуу хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, бараа материалын зарцуулалтыг эд хариуцагч нь бөөн дүнгээр шаардах хуудас бичин зарлагадаж тайлагнасан, тооллогоор хөренге дутагдсан, бараа материалын төлбөр болон ажиллагсдын цалин илүү. дутуу тооцож олгосон, батлагдсан орон тоонд байхгүй ажил хавсруулан нэмэгдэл олгосон зэрэг 93,167.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хууль. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалт, УСНББОУС 1-ийн 27,28 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэн зөв, бодитой, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. | Марал-Алтай өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд Говь-Алтай аймгийн Төрийн аудитын газар дүгнэлт өгөхөөс татгалзсан бөгөөд тус эрүүл мэндийн төвийн нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлын шийдвэрээр дарга С.Эрдэнэчимэгт хөдөлмөрийн тухай хуулийн 123-р зүйлийн 123.2.3 дахь заалтын дагуу үндсэн цалингийн 20 хувиар 3 сар бууруулах сахилгын шийтгэл, нягтлан бодогч Э.Хүжмаагт ажлаас халах арга хэмжээг тус тус авсан. |
| 7 | Говьсүмбэр аймаг | Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Энхтуясэм ЗГБХН өрхийн ЭМТ | ЗГБХН | Аудитыг гүйцэтгэх явцад даравх хязгаарлагдмал нөхцөл байдал үүссэнээс шалтгаалан дүгнэлт өгөхөөс татгалзсан. Үүнд:<br>1.Энхтуясэм Өрхийн эрүүл мэндийн төвийн 2024.01.31-ний өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн аудит хийгээхээс татгалзсан тайлбар<br>2.Аудитад шаардлагатай судалгааг гаргаж ирүүлээгүй, гаргаж өгөхөөс татгалзсан тайлбарыг тус тус ирүүлсэн. | Энхтуясэм өрхийн эрүүл мэндийн төв ЗГБХНөхөрлөл нь төрийн аудитын "Татгалзсан" санал дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзэн 2024.04.18-ны өдрийн 29 тоот албан бичгээр Дорноговь аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хүчингүй болгуулах гомдол гарган одоогийн байдлаар шийдвэр гаргагүй шалгагдаж байна. |
| 8 | Завхан аймаг | Хот тохижилт, үйлчилгээний газар | ОНӨҮГ | Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний алба нь Төсвийн тухай хуулийн цагаалбарт хугацаанд Төрийн аудитын байгууллагад тайлангаа бүртгүүлж, баримтаа хүргүүлээгүй, санхүүгийн тайлан гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажаагүй, авлага өглөгийг тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулаагүй, хөренгийн тооллого хийж, үр дүнг тооцоогүй, тээврийн хэрэгслийн сэлбэгийг техникийн комиссын дүгнэлт гаргалгүйгээр худалдан авдаг, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажилд гэрээ дүгнээсэн баримт, ажлын тайлан, акт үйлдээгүй, жолоочийн тооцооны хуудас болон тооцоо бодсон баримт байхгүй, байгууллагын данс, улсын бүртгэлд бүртгэлгүй тээврийн хэрэгсэлд шатахуун зарцуулсан, бараа материал үндсэн хөренгийн ангилал, ашиглах хугацаог холбогдох стандарт, хууль журамд үндэслэн тодорхойлдоггүй, урсгал засварын зардалд бичигдэх дүнг хөренгийн дансанд капиталжуулсан, албан хаагчдад гарын бэлэг авч өгсөн, спортын арга хэмжээнд төсөөс хөренге зарцуулсан, албан хаагчдад үр дүнгийн урамшуулпыг тушаал, шийдвэргүйгээр бодож олгосон, бараа материалын тайлан гаргадаггүй, анхан шатны баримт эмх цэгцгүй, бүрдэл хангаагүй санхүүгийн баримтаар гүйлгээ хийсэн, өөрийн орлогыг тулган баталгаажуулах нотлох баримт дутуу, байгууллагын дотоод хяналт сул зэрэг нийт 2.057.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. | Улиастай сумын Засаг даргын 2024-02-07-ны өдрийн Б/01 захирамжаар Хот тохижилт, үйлчилгээний газрын дарга Ч.Батсүхийг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн байна. |
| 9 | Өмнөговь аймаг | Цогтцэций сумын Алимантойром ОНӨААТҮГ | ТБӨӨНҮГ | Аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, ажил, үүйлгээ гарсныг нотлох төлбөр төлсөн баримт бичиг, гэрээ, нэхэмлэх болон бусад нотолгоог ирүүлээгүй, шаардлагатай баримт бичиг, гэрээ, нэхэмжлэх болон бусад нотолгоог ирүүлээгүй, шаардлагатай баримт бичгээр хангаагүй тул аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байна. | Алимантойром ОНӨААТҮГ-н эрхлэгч Х.Мандухай нь 2021 онд төрж, хүүхэд асрах чөлөө авсан. Үүнээс хойш буюу 2021 оноос одоог хүртэл тус эмийн сан үйл ажиллагаа явуулаагүй болно. Тус эмийн сан нь 1 орон тоотой, сумын төвөөс зайдуугаас гадна нүүрсний тээврийн үйлчүүлэгчийн тоо эрс буурсан тул 2021 оноос үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | Төв аймаг | Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга | ТТЗ | Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг цаглаварт хугацаанд боловсруулж төрийн аудитын газарт ирүүлээгүй, аймгийн татварын хэлтсийн ирүүлсэн мэдээгээр орон нутагт төвлөрүүлэх орлого 17 нэр төрөлд орлого батлагдсанаас гүйцэтгэлээр нийт дүнгээр 48,604.4 мянган төгрөгөөр буюу 13,8 хувиар тасалсан, нэр төрлөөр тооцвол 14 нэр төрөлд орлого 116,771.2 мянган төгрөгөөр тасарсан, аймгийн ОНӨГ-аас ирүүлсэн судалгаагаар аймгийн ИТХ-ын 2019 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн 113 тоот тогтоолоор "Эрчим хүчний хуучин барилгa"-ыг 52,500.0 мянган төгрөгөөр худалдан борлуулж аймгийн төсөвт төвлөрүүлээгүй зөрчил нь материалаас өргөн тархсан тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас батлагдсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах". Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д "төсвийн төвлөрүүлэн захиргаа хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлбагийн аудитын "Эрх ба үүрэг", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Тасалбар болголт", "Иж бүрэн байх", " Оршин байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. | Төв аймгийн Засаг даргын 2024 оны Б/36 тоот тушаалаар Баяндэлгэр сумын Засаг дарга З.Дэлгэрцэцэгт санууллах сахилгын шийтгэл ногдуулсан. |

**'Асуулга 6 - Асуулгын эхэнд дурдсан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах чиг үүрэг бүхий хүний хувьд Ерөнхий сайд Та хүлээн зөвшөөрч байгаа эсэх; зөвшөөрч байгаа бол дээрх зөрчлүүдийг таслан зогсоох чиглэлд авахаар төлөвлөж буй арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл**

**Монгол банкны зөвшөөрөлгүйгээр арилжааны банкнуудад данс нээсэн.**

Төсвийн тухай хуулийн 35.3-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ" гэж заасан.

Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг банкинд нээх, хаах тайлагнах журам"-д зааснаар арилжааны банкинд төсвийн орлогыг төвлөрүүлэх орлогын тэг үлдэгдэлтэй данс, иргэдэд тэтгэвэр, тэтгэмж олгох холбоотой данс, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын сангийн орлого төвлөрүүлэх данс, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар санхүүжих төслийн данс, бэлэн мөнгөний зарцуулалт гаргах зориулалттай картын данс, Засгийн газрын гадаад, дотоод эх үүсвэрийг дамжуулан зээлдүүлэх дансууд байршдаг болно.

